

## 5.3.2 Шилмэл омог, үүлдрийн мал үржүүлэх төсөл

### (1) Төслийн танилцуулга

Тухайн бүс нутгийн хувьд шилмэл омог, үүлдрийн мал үржүүлэх асуудал нэлээд хүнд болсон, эцэг малаа ойроос сонгодогоос малын чанар муудсан байна. Уг төсөл энэ хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн бөгөөд тооноос чанарт шилжиж улмаар бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулсан.

### (2) Хамрагдах хэсэг, хэрэгжүүлэгч байгууллага

Хамрагдах хэсэг: малчид, хэрэгжүүлэгч байгууллага: сум, аймгийн захиргаа

### (3) Зорилт

#### 1) Төслийн зорилт

Шилмэл үүлдрийн малын тоо толгой нэмэгдэнэ

#### 2) Эрхэм зорилт

Малын үр ашиг сайжирна

### (4) Үр дүн

#### 1) Шилмэл мал үржүүлэх арга барил сайжирна.

Удирдлагын хүрээнд экстейншиний тогтолцоо сайжирна. Сум, аймгийн захиргаа үржлийн шилмэл мал худалдан авах мэдээлэл цуглуулж худалдан авах ажлыг зохион байгуулна. Үржлийн малын сан, малчдаас худалдан авах гэх мэт арга хэмжээ хэрэгжүүлэх замаар шилмэл малыг өсгөн үржүүлэх ажлыг сайжруулна. Сайн чанарын мал худалдан авахад нь зориулж малчдад хөнгөлөлттэй зээл олгох зэргээр эдийн засгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг авч үзэх хэрэгтэй.

Тухайн нутагт шилмэл мал тодорхой хэмжээнд тархсаны дараа үзэсгэлэн худалдаа явуулах, гэрээ байгуулах замаар бүс нутгийн хэмжээнд өргөн нэвтрүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй юм.

#### 2) Мал үржүүлэх мэдлэг арга технологи сайжирна.

Мал эмнэлгийн чадавхийг сайжруулснаар мал үржүүлгийн талаархи малын эмч нарын мэдлэг нэмэгдэн зохиомол хээлтүүлгийн арга нэвтэрнэ.

#### 3) Мал үржүүлэх талаархи малчдын мэдлэг, арга ажиллагаа сайжирна.

Хөтөлбөрт сургалтаар дамжуулан малчид мал үржлийн ажлын талаар мэдлэг олж авна. Малын эмч нарын дотроос болон урьд өмнө нь мал үржүүлэх чиглэлээр мэдлэг, дадлагатай болсон малчдыг бүс нутгийн хүний нөөцийг ашиглах бодлоготой уялдуулан сургагчаар сонгоно. Малчдын өөрсдөө өөрсдийгээ дэмжих хүчин чармайлтыг дэмжихэд эцсийн зорилго чиглэгдэнэ.

Ингэснээр эцсийн дүндээ малчдын бие даан амьдрал ахуйгаа аваад явах хүчин чармайлтыг нь дэмжих замаар нөхцөл байдлыг сайжруулах зорилт тавина.

(5) Хөрөнгө оруулалт

Үржлийн малын санг сайн чанарын малаар бүрдүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох, малчдыг сургах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах

(6) Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйл, ажил үүргийн хуваарь

Говийн бүс нутгийн бэлчээр усны хомсдмол байдлыг харгалзан үзвэл малын үр ашгийг дээшлүүлэх асуудал нь бэлчээр усны нөхцлийг сайжруулах зорилттой нэгэн адил мал аж ахуйн тогтвортой байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай хүчин зүйл болох юм. Энэ төслийн хүрээнд малын үр шимийг дээшлүүлэх асуудал нэн тэргүүний зорилт болон тавигдана. Иймд улсын мал аж ахуйн эрдэм шинжилгээний байгууллагын хүрээнд явагдаж буй шилмэл малын үүлдэр угсааны шинжилгээ, судалгааны асуудалтай холбоогүйгээр орон нутгийн төвшинд малын өнөөгийн байдлыг сайжруулахад чиглэсэн арга замуудыг зөвлөж байгаа юм.

Тэрчлэн туршилтын судалгааны хүрээнд хэрэгжүүлсэн "Малжуулах сан" төслөөр шилмэл малыг зээлээр олгох арга хэлбэрийг нэвтрүүлэх туршилтыг хийж үзсэн бөгөөд, малжуулах сан төсөл нь энэхүү төслийн ихэнх элементийг агуулж байгаа юм. Иймд уг төслийг хэрэгжүүлэх явцад энэхүү тайлангийн 4.6.2-ын "Малжуулах сан төсөл", 4.7.2-ын "Малжуулах сан төсөлд хийсэн эцсийн үнэлгээ"-нд дурьдсан арга барил, сургамж, зөвлөмжийг дээд зэргээр харгалзан үзэх нь чухал юм.

Шилмэл малыг үржүүлэх төслийг доор дурьдсан хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг бий болгож, оролцогч тус бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгосны үндсэн дээр хэрэгжүүлэх шаардлагатай. Богино хугацааны зорилтын хүрээнд боловсон хүчнийг бэлтгэх асуудлыг голлон анхаарч, түүний дараа урт хугацааны зорилтын хүрээнд шаардлагатай орчинг бий болгох асуудлыг шийдвэрлэнэ. Төслийн ажлын үндсэн чиглэлийг доор харуулав. Ялангуяа манай туршилтын судалгааны хүрээнд эхлүүлсэн "Малжуулах сан" төслийг сумын ЗДТГ, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд зудаар малаа алдаж ядууралд орсон малчдыг дэмжин тэтгэх үр дүнтэй арга хэрэгсэл болох нь нотлогдож, бие даасан хөгжлийг хангах боломжтой төсөл болох нь харагдсан тул Засгийн газар энэхүү төслөөс санаа аван ижил төстэй төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгө мөнгийг төсөвлөн, яаралтай хэрэгжүүлэх арга хэмжээ авах нь нь зүйтэй юм.

Хүснэгт 5.3.2 Шилмэл омог, үүлдрийн мал үржүүлэх төсөлд оролцогчдын ажил үүргийн хуваарь.

Хэрэгжүүлэх байгууллага	Үйл ажиллагаа
Засгийн газар(ХХААЯ), холбогдох эрдэм шинжилгээний хүрээлэн	<ul style="list-style-type: none"> <li>• Шилмэл мал худалдан авахад шаардагдах хөрөнгийг төсөвлөх.</li> <li>• "Малжуулах сан" төсөлд шаардагдах хөрөнгийг төсөвлөж, хэрэгжүүлэх. (Шилмэл үүлдрийн мал бий болгох эрдэм шинжилгээ, судалгааны ажил)</li> </ul>
Аймаг (ЗДТГ), ХХАА Газар	<ul style="list-style-type: none"> <li>• Шилмэл омог үүлдрийн малын тухай мэдээлэл цуглуулж, нийлүүлэх зохион байгуулалтыг бий болгох (Сумын ЗДТГ- дэргэд бий болгох боломжтой.)</li> <li>• Мал үржүүлгийн технологийн сургалтыг* зохион байгуулах.</li> <li>• Мал үржүүлгийн технологийн сургалтыг (үргэлжлүүлэн) явуулах, энэ сургалтын явцад малчдын бүлгийн ахлагч нарыг сургаж бэлдэх.</li> <li>• Малын үзэсгэлэн худалдаа</li> </ul>
Сумын ЗДТГ	<p>Улсын төсвөөс санхүүжилт авч :</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шилмэл малаас бүрдсэн сан байгуулан "Малжуулах сан" төслийг хэрэгжүүлэх</li> <li>• Шилмэл мал худалдан авахад шаардлагатай хөнгөлөлттэй зээл авах</li> <li>• Малжуулах санг үргэлжлүүлэн ажиллуулж, дараа дараагийн ээлжийн малын зээлийг олгох.</li> </ul>
Малчид	<p>Мал үржүүлэгтэй холбоотой мэдлэг, технологийг олж авах.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мэдлэг, технологи эзэмшсэн малчдаас бусад малчдад зориулсан сургалт явуулах.</li> </ul>

\*Малчдад мэдээлэл олгох арга хэмжээг хялбар болгохын тулд сургалт явуулах багш нарыг Улаанбаатараас ирүүлэхгүйгээр аль болох орон нутгийн боловсон хүчний нөөц боломжийг ашиглах нь чухал юм.

### 5.3.3 Мал маллагааны арга, технологийг сайжруулах төсөл

#### (1) Төслийн танилцуулга

Нэгдлийг татан буулгасны дараа тэнд ажиллаж байсан албан хаагчдаас олон хүн ажилгүй болсны улмаас мал дээр гарч малчин болжээ. Зах зээлд шилжих шилжилт эхлэснээр Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн задрал, зах зээлийн даяарчлал, чөлөөт худалдаа зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөгөөр аж үйлдвэрийн салбарт бууралт явагдаж тэндээс ажилгүй олон хүн гарч малчин болсон юм. Малчдын туршлага ядмаг болж, энэ байдал эдүүгээгийн залуу малчид дээр бүр илүү ажиглагдаж байна.

Ийм нөхцөл байдалд багийн өдөр зэрэг малчид олноороо нэг газар цуглах үеийг тааруулан мал маллах үндсэн арга барилын талаархи сургалтыг явуулан үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх технологид малчдыг сургах, дадлагажуулах явдал шаардагдаж байна.

#### (2) Хамрагдах бүлэг, хэрэгжүүлэгч байгууллага

Төслийн бүлэг: малчид, Хэрэгжүүлэгч байгууллага: сум, аймгийн захиргаа

#### (3) Зорилт

##### 1) Төслийн зорилт

Малчдын мал маллах арга барилыг сайжруулах.

## 2) Эрхэм зорилго

Малын үр ашиг нэмэгдэнэ

### (4) Гарах үр дүн

- 1) Мал маллах арга барил, туршлага багатай малчдын тоо цөөрөх (Малчин малчдыг сургах сургалт явуулах)

Туршлага багатай малчдыг туршлагатай малчдыг дагалдуулах, хот айл байгуулах, малчдын туршлага, арга барилыг бусдад нь түгээн дэлгэрүүлэх зорилгоор малчнаас малчинд чиглэсэн сургалтыг туршилтын журмаар явуулна. Тэрчлэн тогтсон хугацаанд малчдаар тойрох явцдаа технологи, арга барилын заавар зөвлөмж өгч байна.

- 2) Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн технологи сайжрах

Үндсэн технологи арга ажиллагааг тусгасан материал (тухайлбал, өвөлжилтийн бэлтгэл хангах, мал сүргийн усан хангамжийг сайжруулах, зун-намрын отор, нэмэгдэл тэжээлийн төрөл, тэжээх хугацаа, мал хээлтүүлгийн хугацаа, төл бойжуулах, нэг настай малын маллагаа, гар тэжээл бэлтгэх тухай, ноос ноолуур ангилал гэх мэт) тарааж, сургалт явуулна. Чадвартай, туршлагатай, мэдлэгтэй малчныг орон нутгаас сонгож сургагчаар ажиллуулна. Эсвэл туршлагатай малчны ахалсан хот айлыг түшиглэсэн практикийн сургалт явуулна.

- 3) Малчид мал аж ахуй эрхлэх менежментийн үндсэн мэдлэгт суралцана.

Мал аж ахуй эрхлэх менежментийн асуудалтай холбоо бүхий санхүү нягтлан бодох, тооцоо тоо бүртгэл, мал аж ахуй эрхлэх менежментийн анхан шатны мэдэгдэхүүнийг тусгасан ном зохиож, түүнийг ашиглан дараа нь малчдад сургалт явуулна.

### (5) Хөрөнгө оруулалт

Мал аж ахуйн технологийн сургалтад багшлах, хамрагдах малчин сургалтын зардал, мал аж ахуйн үйлдвэрлэлийн анхан шатны технологийн гарын авлага, сургалтын зардал, мал аж ахуй эрхлэх менежментийн гарын авлага, сургалтын зардал

- (6) Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйл, ажил үүргийн хуваарь

Мал маллагааны арга барил дутмаг малчдад зориулан малчид хоорондын сургалтын тогтолцоог бий болгосноор сургалтыг тогтмол шинж чанартай болгох боломж бүрдэнэ. Мөн үндсэн арга ажиллагааны заавар зөвлөмжийг боловсруулан тараана. Өнөөгийн мал аж ахуйд эдийн засгийн зарчим, арга хэрэгслийг нэвтрүүлэх шаардлагатай тул менежментийн анхан шатны мэдлэг олгох сургалт явуулна.

**Хүснэгт 5.3.3 Мал маллагааны арга, ажиллагааг сайжруулах төсөлд оролцогчдын ажил үүргийн хуваарь**

Хэрэгжүүлэх байгууллага	Үйл ажиллагаа
Засгийн газар(ХХААЯ)	<ul style="list-style-type: none"> <li>• Үндсэн арга ажиллагааны заавар зөвлөмжийг боловсруулахад шаардлагатай хөрөнгө төсөвлөх, боловсруулах, тараах</li> <li>• Арга технологийн сургалтын зардлыг төсөвлөх</li> </ul>
Аймаг (ЗДТГ)	Арга технологийн сургалтыг зохион байгуулах
Сумын ЗДТГ	Сургалтыг удирдан явуулах шилдэг малчдыг тодруулах, хүсэлт тавих.
Малчид	Мал аж ахуйн суурь технологийг эзэмших, шилдэг малчнаас бусад малчдад зориулсан сургалт явуулах.

**5.3.4 Эрсдэлийн менежментийн чадварыг дээшлүүлэх төсөл**

(1) Төслийн танилцуулга

Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулж, салбарын хэмжээний хөгжлийг урагшлуулахын тулд хөдөөд мал аж ахуй эрхлэлтийн техник технологийг сайжруулах зэргээр үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэхээс гадна тухайн салбарт тохиолдох төрөл бүрийн эрсдэлийг бууруулж, мал аж ахуйн бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэлтэй холбож өгөх шаардлагатай. Ийм тогтвортой байдлын үндсэн дээр бүтээгдэхүүний чанарын олон улсын стандартыг нэвтрүүлж, чанар сайтай, аюулгүй бүтээгдэхүүн нийлүүлэхийг зорих нь алсдаа мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нэгэн чухал эх үүсвэр болох юм.

(2) Хамрагдах бүлэг, Хэрэгжүүлэгч байгууллага

Хамрагдах бүлэг: Сум, аймгийн захиргаа.

(3) Зорилт

1) Төслийн зорилт

Хөдөөд тохиолдох гамшгийг даван туулах, өвчнөөс сэргийлэх чадавхийн хувьд улам бэхэжсэн мал аж ахуй эрхлэх тогтолцоо бүрдүүлэх.

2) Эрхэм зорилт

Хөдөөгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулж, цаашид үргэлжлүүлэн нэмэгдүүлэх.

(4) Гаргах үр дүн

1) Тэжээлийн нөөц бүрдүүлэх систем тогтоно.

Одоо байгаа Улсын тэжээлийн фондын тогтолцооноос гадна сумын ЗДТГ-ын дэргэд малын тэжээлийн сан байгуулж, тэжээл авахыг хүссэн малчдад худалдана.

2) Мал хашаажуулалт сайжирна.

Шаардлагад нийцүүлэн малын хашаа саравчийг засварлах буюу шинээр барина.

3) Малын даатгалын тогтолцоонд малчдыг хамруулах.

Одоо малын даатгалын системийг өөрчлөн шинэчлэх ажил явагдаж байгаа бөгөөд энэ асуудал шийдэгдсэний дараа малчдад малын даатгалын ач холбогдол, даатгалд хамрагдах журмыг сайтар ойлгуулж, даатгалд хамруулахын тулд ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

4) Цаг агаарын мэдээ, урьдчилан сэрэмжлүүлэх тогтолцоог сайжирна.

Цаг агаарын мэдээ, мэдээллийн сүлжээ сайжирсаар байгаа тул малчдад уг мэдээллийг бүрэн хүргэх тогтолцоог бий болгоно. Цаг агаарын мэдээ, анхааруулга, урьдчилан сэрэмжүүлэх мэдээ өгөх зэргээр малчдад мэдээлэл хүргэх орчныг сайжруулна. Мэдээллийг олон нийтэд зарлан түгээхэд самбар, утасгүй холбоо, радио зэргийг ашиглахаар бодолцоно.

5) Өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний үзлэг шалгалт хийх олон нийтийн тогтолцоо сайжирна.

Дараах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай.

- Улсаас зарлан мэдээлсэнд үндэслэсэн хяналт-сэрэмжлүүлгийн системийг бэхжүүлэх (өвчтэй болон сэжиг бүхий малыг олж илрүүлэх, өвчний байдлыг оношлох, тогтоосон оношийн дагуу хамгаалалт, устгал хийх, шилжилт хөдөлгөөний хязгаарлалт тогтоох, вакцинжуулах, ариутгал хийх, тус асуудалтай тэмцэх төв газрыг ажиллуулах зэргээр системийн хэмжээнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэс дараалал, арга замыг тодорхой болгож, зөвхөн удирдлагын түвшинд бус малчдад ч мэдээллийг өргөн хүргэж байх.)
- Мал халдваргүйжүүлэлтийн тогтолцоог бэхжүүлэх (Мал угаалгын онгоцыг сэргээн засварлах, шинээр барих)

6) Малын хулгайн гэмт хэргийн гаралт буурна.

Дор дурьдсан арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай.

- Малын хулгайд ноогдуулах арга хэмжээг чангатгах.
- Олон нийтийн байгууллагуудаас малын хулгайгаас урьдчилан сэргийлэх зар мэдээлэл хүргэх, боловсролын байгууллагуудаас сургалтын арга хэмжээ хэрэгжүүлэх.
- Малыг зэмэгжүүлэх, тамгажуулах ажлыг хэрэгжүүлэх.

(5) Хөрөнгө оруулалт

Нөөц тэжээл худалдан авах зардал, хашаа хороо засаж сэлбэх, шинээр барих зардал, цаг агаарын урьдчилан сэрэмжлүүлэх мэдээллийн сүлжээг сайжруулах зардал, мал угаалгын онгоц барих, сэргээн засварлах зардал.

(6) Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйл, ажил үүргийн хуваарь

Энэ төслийн хамрах хүрээ өргөн, оролцох малчид олон. Төслийг амжилттай хэрэгжүүлэх үүднээс ХХААЯ гол цөм нь болж холбогдох байгууллагуудын уялдаа холбоотой бүтэц, зохион байгуулалтыг бий болгох нь чухал юм.

Эрсдэлийн менежментийн чадварыг бэхжүүлэх төслийг доор дурьдсан хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг бий болгож, оролцогч тус бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгосны үндсэн дээр хэрэгжүүлэх шаардлагатай.

Туршилтын судалгаагаар хэрэгжүүлсэн "Малжуулах сан" төслийн хүрээнд малын даатгалын болон тэжээл бэлтгэх зохион байгуулалтыг бий болгох ажлыг туршин хэрэгжүүлж үзсэн болно. Малчдад малын даатгалтай холбоотой мэдээлэл дутмаг байдаг тул агуулга, ач холбогдлыг нь ойлгуулж, даатгалд хамрагдахыг уриалах нь чухал юм. Малын тэжээлийн бэлтгэл, нийлүүлэлтийн систем аймгийн төвшинд бүрэлдсэн байдаг боловч, ихэвчлэн машин машинаар зардаг тул бага багаар авахад хүндрэлтэй байдаг. Мөн малчид гар дээрээ мөнгөгүй үедээ ч тэжээл авах боломжийг бүрдүүлэх үүднээс албан ёсны дэмжлэгийн тогтолцоог бий болгох нь чухал бөгөөд үүнд малчдад ойрхоноор нь сумын ЗДТГ-ын дэргэд тэжээл нөөцлөх зохион байгуулалтыг<sup>1</sup> бий болгох нь оновчтой юм.

Хүснэгт 5.3.4 Эрсдэлийн менежментийн чадварыг бэхжүүлэх төсөлд оролцогчдын ажил, үүргийн хуваарь.

Хэрэгжүүлэх байгууллага	Үйл ажиллагаа
Засгийн газар (ХХААЯ)	<ul style="list-style-type: none"><li>• Хашаа, саравч барихад шаардлагатай хөрөнгийг төсөвлөх.</li><li>• Малын даатгалын системийн хууль, журмыг дахин судалж үзэх.</li><li>• Урьдчилан сэргийлэх, вакцинжуулах тогтолцоог бий болгох.</li><li>• Малын хулгайгаас сэргийлэх арга хэмжээ, анхааруулга, мал зэмэгжүүлэх, тамгажуулах ажлыг судлан хэрэгжүүлэх, хөрөнгө төсөвлөх, хүлээлгэх хариуцлагыг чангатгах хуулийн төслийг судалж үзэх.</li><li>• Малын даатгалын системийг нэвтрүүлж эхлэх</li></ul>
Ус цаг,уурын удирдах газар (ХАА-н Хоршоологчдын Холбоо)	Малчдад цаг агаарын мэдээг хүргэх тогтолцоог сайжруулах (ХХААЯ-тай хамтран)
Аймаг (ЗДТГ)	<ul style="list-style-type: none"><li>• Хашаа саравчийг сэргээн засварлах, шинээр байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулах.</li><li>• Малын хулгайгаас урьдчилан сэргийлэх анхааруулга, мэдээлэл хүргэх</li></ul>

<sup>1</sup> Туршилтын судалгаагаар хэрэгжүүлсэн "Малжуулах сан" төслийн хүрээнд малчдад өвс тэжээлийг зээлээр олгож, ноолуурын борлуулалтаас орлого ордог 3 сард үнийг нь нөхөн төлөх төлбөрийн журмыг тогтоосон. 3-р сар хүртэлх нөхөн төлбөрт хүү ноогдохгүй бөгөөд төлбөр заасан хугацаанаас хойшилсон тохиолдолд хүү тооцохоор тогтоосон болно. Гэвч бодитоор ийм зохион байгуулалтыг бий болгох тохиолдолд сангийн хэвийн ажиллагааг хангах үүднээс төлбөрийн дүнд хүү тооцож дараа нь нөхөн төлүүлэх хэлбэрийг нэвтрүүлэхийг зөвлөж байна.

Сумын ЗДТГ	<ul style="list-style-type: none"> <li>• Тэжээл бэлтгэлийн тогтолцоог (тэжээлийн сан) бий болгох</li> <li>• Аймгийн ЗДТГ-тай хамтран малын хулгайгаас урьдчилан сэргийлэх мэдээлэл тараах.</li> </ul>
БСШУЯ	Малын хулгайгаас урьдчилан сэргийлэх сургалт (ялангуяа анхан шатны боловсролд ёс суртахууны асуудлыг тусгаж өгөх нь чухал.)

## **5.4 Малчин өрхийн орлогыг тогтворжуулах бүрэлдэхүүн хэсэг**

Зах зээлд шилжсэний дараа төлбөргүй байсан нийгмийн үйлчилгээний хуучин тогтолцоо үндсэндээ төлбөртэй болж бэлэн мөнгөөр төлбөр хийх шаардлага нэмэгдэн бэлэн мөнгөний хэрэгцээ ч нэгэн адил өссөн билээ. Гэхдээ шаардагдах хэмжээний бэлэн мөнгөтэй болох орлого олж чаддаггүй, тийм боломж ч хязгаарлагдмал болсон билээ. Мал аж ахуйгаа өгөөжтэй эрхлэхэд хэрэглээ, борлуулалтаар бүхнийг хязгаарлах бус өртөг нэмэгдүүлэх боловсруулалт хийж бүтээгдэхүүнийхээ эрэлтийг нэмэгдүүлэх, улмаар орлогын эх үүсвэр бий болгох шаардлага тулгарч байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүн бэлтгэлийн тогтолцоо задарснаас болж малчид мал аж ахуйн бүтээгдэхүүнээ борлуулах байнгын суваг ийм замаар устсан юм. Зах зээлийн мэдээлэл байхгүйн улмаас малчид зуучлагч, чэйнжүүдтэй шууд тулж, хувь хувиараа харьцахад хүрсэн нь үнийг ямагт доогуур барьж малчдад алдагдалтай нөхцлийг бий болж байгаа юм. Хөдөөгийн нийгмийн дэд бүтэц ч гэсэн онцын сайжралыг олоогүй хэвээрээ байна.

Иймэрхүү нөхцөл байдлыг даван туулахын тулд малчдын эдийн засгийн чадавхийг тогтворжуулах дэд хэсгийн хүрээнд i) Мал аж ахуйн эрхлэлтийн менежментийг сайжруулах төсөл, ii) Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах гэсэн 2 төслийг хэрэгжүүлнэ.

### **5.4.1 Мал аж ахуй эрхлэлтийн менежментийг сайжруулах төсөл**

#### **(1) Төслийн танилцуулга**

Хөдөөд мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэрлэлийн бизнесийг дэмжих замаар мал аж ахуйн бүтээгдэхүүний өртөг нэмэгдүүлнэ. Төслийн хүрээнд орлого олох, бизнес эрхлэх боломжийг олгож малчид болон хөдөөгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэх зорилт тавьсан болно.

#### **(2) Хамрагдах бүлэг, хэрэгжүүлэгч байгууллага**

Хамрагдах бүлэг: малчид, Хэрэгжүүлэгч байгууллага: сум, аймгийн захиргаа



### (3) Зорилт

#### 1) Төслийн зорилт

Малчид, хөдөөгийн иргэд мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэрлэл эрхэлж эхэлнэ.

#### 2) Эрхэм зорилт

Хөдөөд мал аж ахуй эрхлэх ажил хөгжинө. Малчид, хөдөөгийн иргэд орлого олох, бизнес эрхлэх боломж нэмэгдэнэ.

### (4) Гарах үр дүн

#### 1) Орон нутгийн иргэд, малчид мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах технологийн талаар арга туршлага эзэмшинэ.

Малчид, оршин суугчдын санал, хүсэлтийн дагуу мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэрлэлийн төслийг хэрэгжүүлэх тохиолдолд малчид, оршин суугчид санал гаргахаасаа өмнө уг төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник, технологийн асуудлыг сайтар ойлгосон байх шаардлагатай. Үүний тулд боловсруулалтын технологийн сургалтыг (ноос,сүү, мах боловсруулалт зэрэг) амжилттай хэрэгжсэн ижил төстэй төсөл болон холбогдох Төрийн бус байгууллага дээр зохион байгуулна. Сургалтад хамрагдагсад сургалтын зардлаа бүтнээр нь эсвэл нэг хэсгийг нь хариуцах бөгөөд сум, аймгийн ЗДТГ-тай хамтран сургалт зохион байгуулах асуудлыг шийднэ.

#### 2) Орон нутгийн иргэд, малчид эдийн засгийн ба менежментийн дадлага эзэмшинэ.

Малчид, оршин суугчдын бүлгүүд нь 1) -д дурьдсан технологийн сургалтын явцад олж авсан мэдлэг, мэдээлэл дээрээ тулгуурлан төслийн саналыг боловсруулна. Сумын ЗДТГ нь малчид, оршин суугчдаас ирсэн төслийн саналуудыг судалж үзсний үндсэн дээр зохион байгуулалттай менежментийн үйл ажиллагаа явуулах талаар заавар, зөвлөмж өгнө.

#### 3) Хөдөөд мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэрлэлийн бизнесийг санхүүжүүлэх тогтолцоо сайжирна.

Бизнес эхлэхэд шаардагдах эхлэхийн хөрөнгө оруулалтад шаардагдах мөнгө олгогдоно. Сум хөгжүүлэх сангийн мөнгийг энэ зорилгоор ашиглах нь тохиромжтой. Засгийн газрын хөрөнгө оруулалтаас юм уу бусад хөрөнгөөс сум хөгжүүлэх санд хуримтлуулж, малчид, иргэдийн бизнесийн төслийг шалгаруулсны дараа сумын захиргаанаас санхүүжүүлэлтийг хийж эхлэнэ.

Санхүүжилт олгох шалгуур нь зохих технологийн сургалт, менежментийн сургалтад хамрагдсан байх шаардлагатай ба түүнээс гадна үйлдвэрлэгч бүлгийн байгууллага, түүний үйл ажиллагааны төлөвшилт, сургалтын арга

технологи (санал хүсэлт) гэх мэт олон асуудлыг харгалзан үзнэ. Төслийг баримт материалд тулгуурлан шалгах ба захиргаанаас эрхлэн ярилцлага хийнэ.

(5) Хөрөнгө оруулалт

Малчид, иргэд мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг бизнес эхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, санхүүжилтэд шаардагдах хөрөнгө санхүүжилт ба боловсруулах технологийн эксперт. Менежмент, эдийн засгийн мэргэжилтэн, танилцах айлчлал (өгөөжтэй арга туршлагын сургалт) , бусад сургалтын зардал

(6) Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйл, ажил үүргийн хуваарь

Туршилтын судалгааны явцад малчдын санал хүсэлтийг тодруулахад уст цэг байгуулах замаар ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийг эзэмших зорилтын дараа Мал аж ахуй эрхлэлтийг сайжруулах төслийн бүрэлдэхүүн хэсгүүд малчдын сонирхлыг ихээхэн татаж байгаа нь тогтоогдсон болно. Зах зээлд шилжээд 15 жил өнгөрөхөд Улаабаатар хот болон түүний ойр орчмын хөгжлийг нүдээрээ үзэж буй орон нутгийн малчид хот хөдөөгийн ялгааг ихээхэн мэдэрч, энэ ялгааг арилгах, малчдын амьжиргааг дээшлүүлэхэд шаардлагатай орлогын эх үүсвэрийг бий болгох, орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг үгүйлж байна. Ийм ч учраас энэ нь мал аж ахуйн салбарыг бүхэлд нь урагшлуулан хөгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой төсөл юм.

Туршилтын судалгааны хүрээнд “Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах”, “Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах” 2 төслийг мал аж ахуй эрхлэлтийг сайжруулах төслийн загвар судалгаа болгон авч үзсэн болно. Энэ 2 төслийг хэрэгжүүлэх явцад малчдад зохион байгуулалттай бүлгийн үйл ажиллагааг явуулах арга, туршлага дутагдаж байсан тул үйлдвэрлэл, борлуулалт, нийлүүлэлтийн үе шатнаас оролцооны хэлбэрийн сургалт, семинарыг зохион байгуулж, тооцоо бүртгэлийн мэдлэг олгох шаардлагатай болсон юм. Гарсан үр дүнгээс нь харахад энэ нь маш чухал ач холбогдолтой ажил болсон бөгөөд, төслийн тогтвортой үргэлжлэх нөхцөл, ил тод байдлыг хангах үүднээс амжилтанд хүргэсэн гол хүчин зүйлийн нэг байлаа.

Нөгөө талаар үйл ажиллагааг гардан явуулагч орон нутгийн засаг захиргааны хувьд Мал аж ахуй эрхлэлтийг сайжруулах төсөл нь бага хэмжээний хөрөнгөөр ихээхэн үр нөлөөлөлтэй үр дүнг бий болгох найдлагыг төрүүлж байгаа юм. Энэ нь Сумын хөгжлийн санг ашиглан шуудхан хэрэгжүүлж эхлэх боломжтой төсөл юм. Туршилтын судалгааны хүрээнд хэрэгжсэн төслүүдийн үр дүнг орон нутгийн засаг захиргаа шалгаж, зээлийн агуулгыг магадлан, ил тод үйл ажиллагаагаар дамжуулан дараа дараагийн төслүүдийг тодорхойлох шаардлагатай. Иймд 4 дүгээр бүлэгт дурьдсанчлан Туршилтын судалгаанд хэрэглэсэн санал дэвшүүлэх аргачлал болон сонгох арга хэлбэрээс санаа аван хэрэгжүүлэх төслүүдийг сонгож, хамрагдах

малчдын бүлгүүдийг шалгаруулах ажлыг орон нутгийн засаг захиргаа (Туршилтын судалгааны хувьд сумын ЗДТГ) хариуцан гүйцэтгэх шаардлагатай болно.

Мал аж ахуй эрхлэлтийг сайжруулах төслийг доор дурьдсан хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг бий болгож, оролцогч тус бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох үндсэн дээр хэрэгжүүлэх шаардлагатай. Дээр өгүүлсэнчлэн орон нутгийн малчдад зориулан зах зээлийн эдийн засаг, ня-бо бүртгэлийн мэдлэг, менежментийн чадвар олгох, шинэ технологи, боловсруулалтын технологи эзэмшүүлэхэд чиглэсэн хүн хүчний сургалтын асуудал нэн тэргүүнд чухлаар тавигдах болно.

**Хүснэгт 5.4.1 Мал аж ахуй эрхлэлтийн менежментийг сайжруулах төсөлд оролцогчдын ажил, үүргийн хуваарь.**

Хэрэгжүүлэх байгуулаг	Үйл ажиллагаа
Засгийн газар (ХХААЯ)	• Жижиг хэмжээний боловсруулалтын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор сумын төсөвт хөрөнгө хуваарилж өгөх.
Аймаг (ЗДТГ)	• Орон нутагт зохион байгуулах технологи, менежментийн сургалтын хөтөлбөр боловсруулах • Технологи, менежментийн чадвар олгох сургалтыг зохион байгуулах*
Сумын ЗДТГ	• Малчид иргэдийг зохион байгуулалтад оруулах • Технологи, менежментийн чадвар олгох сургалтыг зохион байгуулах* • Малчдаас ирүүлсэн төслийн саналуудыг нягталж үзэх • Сумын хөгжлийн санг ашиглах • Эхний зээлээс буцаан төлөгдсөн хөрөнгөөр санжүүжилт олгох шинэ төслийг тодруулах.
Малчид	• Сургалтанд хамрагдах • Менежментийн чадвар эзэмших • Төслийн санал боловсруулах • Зээлийг буцаан төлөх • Шинэ төслийг санал болгох
Төрийн бус байгууллага, амжилттай хэрэгжсэн төсөл	• Сургалтанд хамрагдагсдыг хүлээн авах

\*Малчдад мэдээлэл олгох арга хэмжээг хялбар болгохын тулд сургалт явуулах багш нарыг Улаанбаатараас ирүүлэхгүйгээр аль болох орон нутгийн боловсон хүчний нөөц боломжийг ашиглах нь чухал юм.

**5.4.2 Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах төсөл**

**(1) Төслийн танилцуулга**

Мал аж ахуйн түүхий эд, боловсруулсан бүтээгдэхүүнээ зах зээлд шууд нийлүүлэхэд шаардагдах сургалт болон хүний нөөцийг чадавхжуулах сургалт явуулна. Цаашилбал, сумын төв, аймгийн төв зэрэг газар орон нутгийн зах зээлд үйлдвэрлэгч (малчид)-ын хандах нөхцөлийг сайжруулах зорилгоор орон нутгийн зам, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн байгууламжуудыг сайжруулах, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоо бүхий төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нь тус төслийн агуулга болно.

(2) Хамрагдах бүлэг, хэрэгжүүлэгч байгууллага

Хамрагдах бүлэг: Сум, аймгийн захиргаа

(3) Зорилт

1) Төслийн зорилт

Орон нутгийн мал аж ахуйн зах зээлийг өргөжүүлэн хөгжүүлэх

2) Эрхэм зорилт

Орлого, ажил эрхлэлтийн боломж бүрдүүлж, орлого нэмэгдүүлэх

(4) Гарах үр дүн

1) Зах зээлийг бий болох (орон нутгийн түвшинд худалдаа арилжаа явуулах зах зээлийн бааз суурийг хөгжүүлэх)

Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг худалдаалахад гол зүйл болох зэх зээл бий болгоно. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг худалдаалах, борлуулах бааз суурийг хөгжүүлэх боломж, шаардлагыг судлан дэд бүтцийг сайжруулна. Зам дагуу ойрын үед шинээр нээхээр төлөвлөж буй газрууд, төмөр замын өртөө, зогсоолын орчмын байрлалууд болон жуулчны баазыг анхаарч авч үзнэ. Сумын захиргаа дээрхи чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөө боловсруулах, борлуулалтыг төлөвлөхөд гол үүрэг гүйцэтгэнэ.

2) Зах зээлийн талаар малчид, иргэдийн мэдлэг олж авна. (малчдыг зохион байгуулах, хамтарч борлуулах, хоршсон бизнес эрхлэх)

Малчид, иргэдэд таарамжтай зах зээлийн талаар сургалт явуулна. Түүнчлэн зохион байгуулалт, менежментийн сургалт явуулахын дээр хоршсон бизнесийг дэмжинэ.

3) Зах зээлийн дэд бүтэц (зам, цахилгаан, харилцаа холбоо, төмөр зам гэх мэт) сайжирна.

Үндэсний буюу улсын төсвөөс ихээр хамаардаг боловч нийгмийн дэд бүтцийг сайжруулах нь шинэ бизнес бий болгох, зах зээлд хүрэхэд дөхөм үзүүлдэг гэдэг агуулгаар мал аж ахуй эрхлэх системд нэн чухал төдийгүй сайн дэд бүтцийн өгөөж өндөр, хүлээж болох үр дүн ч их байдаг.

4) Зах зээлийн мэдээллийн ашиглалт сайжирна.

Аймгийн ЗДТГ сард 1 удаа аймгийн төвд борлуулагдаж буй мал аж ахуйн бүтээгдэхүүний үнийг судалж тодруулан, ойр хавийн зах зээл, Улаанбаатарын зах зээлийн үнэтэй нэгтгэн баяжуулаад мэдээллийн самбар, радио, богино долгионы радио зэрэг мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан олон нийтэд хүргэх арга хэмжээ авна. Ийм мэдээ хүлээн авснаар худалдах үнэ тохиролцох, борлуулах хугацаагаа товлох, бүтээгдэхүүнээ зах зээлд хоршин нийлүүлэх талаар малчид дор бүрнээ шийдвэр гаргана.

5) Мал аж ахуйн бүтээгдэхүүний (хонины ноос, ноолуур) стандарт нэвтрүүлэх.

Орон нутгийн зах зээлд мал аж ахуйн бүтээгдэхүүний стандартыг нэвтрүүлнэ. Зах зээлд ажиллагсад, үйлдвэрлэгчдэд стандартыг самбар, зурагт хуудас, товхимлоор дамжуулан нэвтрүүлж, аймгийн ЗДТГ-аас хяналт шинжилгээ хийж, заавар зөвлөмж өгнө.

Сайн чанарын бүтээгдэхүүнийг (хонины ноос, ноолуур) өндөр үнээр борлуулах системийг бий болгох ажлын эхний алхам болгож стандартыг нэвтрүүлснээр харьцангуй өндөр нэмүү өртөгтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг урагшлуулахын зэрэгцээ мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтаас орох орлогыг сайжруулах найдлага төрж байна. Сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагаас үүдэн мал болон мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын технологийг сайжруулан үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой болно. Тэрчлэн стандартчиллыг нэвтрүүлснээр мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтыг харьцангуй шударгаар явуулах боломжтой болно.

“Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах” туршилтын төслийн хувьд иргэдийн бүлэг нь өөрсдийн тээврийн хэрэгсэл байхгүйгээс түүхий эдийн нийлүүлэлтийн тал дээр харьцангуй ашиггүй байр суурьтай байсан тул чанар муутай ноосыг ч авахаас өөр аргагүй байдалд орж байлаа. Ийм тохиолдолд түүхий эдийн стандарт дээр тулгуурлан үнийн хэлэлцээр хийвэл шударга гэрээ байгуулах боломжтой болохоос гадна малчид ч гэсэн үйлдвэрлэлээ худалдан авагчдын хэрэгцээнд чиглүүлэн, худалдагч, худалдан авагчийн аль алиных нь эрх ашигт нийцүүлэх боломжтой болох юм. Одоогоор хонины ноосны батлагдсан стандарт байдаг боловч түүнийг амьдралд хангалттай нэвтрүүлэхгүй байна.

(5) Хөрөнгө оруулалт

Эдийн засгийн зөвлөх мэргэжилтэн, төрөл бүрийн бүтээгдэхүүн боловсруулах мэргэжилтэн, сургалт явуулах газрыг тогтоох, нийгмийн дэд бүтэц сайжруулах (зах зээл, захын бааз, зам, холбоо гэх мэт). Мал аж ахуйн бүтээгдэхүүний стандартын товхимол, зурагт хуудас хэвлэх зардал.

(6) Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйл, ажил үүргийн хуваарь

“Бүрдэний сувилалд сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах” туршилтын төслийг мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, нийлүүлэлтийг сайжруулах загвар судалгааны нэг хэсэг болгон авч үзсэн болно. Энэ нь орон нутагт мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын цэгийг бий болгон мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг өргөжүүлэх, малчдын орлогын шинэ эх үүсвэрийг бий болгох, орлогыг нь нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгыг агуулж байлаа. Эндээс бүтээгдэхүүний борлуулалтын цэгийг бий болгоод зогсохгүй ойр хавийн малчдыг

зохион байгуулалтанд оруулж хамтарсан үйл ажиллагаа явуулбал өндөр үр дүнд хүрч болох нь харагдсан болно. Борлуулалтын цэгийг бий болгохтой хамт орон нутгийн засаг захиргааны (ялангуяа малчдад хамгийн ойрхон байдаг сумын ЗДТГ болон багийн дарга нар) зүгээс малчдыг зохион байгуулалтанд оруулах ажлыг явуулбал зохино. Ингэснээр ганц нэгээрээ хийхэд амаргүй борлуулалтын гэрээг амжилттай хийх, үйлдвэрлэлийн хүндрэлээс зайлсхийх, зах зээлийн мэдээлэл дээр үндэслэн нийлүүлэлтийн цаг хугацааг зохицуулах, ашгийг дээд хэмжээнд нэмэгдүүлэх зэрэг янз бүрийн давуу талуудыг малчдад олгох боломжтой юм

Орон нутгийн засаг захиргаа нь төмөр замын өртөө, сургууль, эмнэлэг, үйлдвэр зэрэг сүү, сүүн бүтээгдэхүүнийг борлуулж болох газруудыг олж, ойр хавийн малчдын хүч хөдөлмөрийг нэгтгэх талаар хүчин чармайлт гаргах шаардлагатай. Туршилтын төслийн хүрээнд сумын ЗДТГ-ын сувилалд ойр хавийн малчид эмчилгээний зориулалтаар ингэний сүү нийлүүлсэн болно. Гэвч борлуулалтын цэгийн ойр орчмын бэлчээр тааруу байвал малчид сайн бэлчээр, ус хөөгөөд тарж одох тул борлуулалтын цэгийн ойр хавийн бэлчээрийн байдал нь төслийн хэрэгжилтэнд нөлөөлөх гадаад хүчин зүйл болж байна.

Мөн малчид зах зээлийн мэдээллээр хомс, бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх арга хэрэгсэл хязгаарлагдмал байна. Үүний үр дүнд ченжүүдэд хямдхан өгөхөөс өөр аргагүй байдалд орж байна. Энэ байдлыг өөрчлөхийн тулд малчид зохион байгуулалтанд орж, хамтран хэлэлцээр хийж, хамтран борлуулах замаар хүндрэлээс гарахыг зорих нь чухал байна. Тэрчлэн малчдын хувьд зах зээлийн мэдээллийг олж авах нь бэрхшээлтэй байдаг тул мэдээллийн самбар, богино долгионы радио, радио өргөн нэвтрүүлэг ашиглан тэдэнд холбогдох мэдээллийг хүргэх шаардлагатай байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах төслийг доор дурьдсан хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг бий болгож, оролцогч тус бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох үндсэн дээр хэрэгжүүлэх шаардлагатай. Дараахь хүснэгтэд төсөлд оролцогчдын ажил, үүргийн хуваарийг харуулав.

Хүснэгт 5.4.2 Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах төсөлд оролцогчдын ажил үүргийн хуваарь.

Хэрэгжүүлэх байгууллага	Үйл ажиллагаа
Засгийн газар (ХХААЯ)	Орон нутагт борлуулалтын цэг бий болгоход дэмжлэг үзүүлэх, хөрөнгө төсөвлөх
Аймаг (ЗДТГ)	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутагт борлуулалтын цэг бий болгох төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах</li> <li>• Зах зээлийн мэдээллийг судлах, малчдад хүргэх.</li> </ul>
Сумын ЗДТГ	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутагт борлуулалтын цэг бий болгох төлөвлөгөөг гаргах</li> <li>• Зах зээлийн эдийн засгийн сургалтыг явуулах</li> </ul>
Малчид	<ul style="list-style-type: none"> <li>• Зохион байгуулалтанд орох, хамтран борлуулах үйл ажиллагааг явуулах</li> <li>• Зах зээлийн эдийн засгийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх.</li> </ul>

## 5.5 Хүний нөөцийг хөгжүүлэх төсөл

### (1) Төслийн танилцуулга

Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг сайжруулах, малчдын эдийн засгийн чадавхийг тогтворжуулах гэсэн гурван хэсгээс гарах үр дүн, өгөөжийг төгөлдөржүүлэхэд хүний нөөцийн хөгжил нэн чухал гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй.

### (2) Хамрагдах бүлэг, хэрэгжүүлэгч байгууллага

Хамрагдах бүлэг: малчид, иргэд, сум, аймгийн захиргааны ажилтнууд

### (3) Зорилт

#### 1) Төслийн зорилт

Хөдөөд мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд оролцогчдын чадавхи сайжирна.

#### 2) Эрхэм зорилт

Иргэд, малчид өөрсдийн санаачлагаар зохион байгуулалттай үйл ажиллагааг эхлүүлэх

### (4) Гарах үр дүн

1) Захиргаа орон нутгийн мал аж ахуйн төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн малчид, иргэдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой болно.

i) Худгийн ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр малчдыг зохион байгуулалтад оруулах ажиллагаа

Худаг ашиглах, засвар үйлчилгээний чиглэлээр малчид бүлэг байгуулахдаа дараахь үйл ажиллагааг даган хэрэгжүүлэх ёстой. Сумын захиргаанаас тэдэнд чиглэл удирдамж чиглэл өгч малчдыг зүй зохистой зохион байгуулалтад оруулахад зохих дэмжлэг үзүүлнэ.

#### Хүснэгт 5.5.1 Худгийн ашиглалт, засвар үйлчилгээг зохион байгуулах ажиллагаа

А. Малчид хурал хийж (эхний хурал) дараах асуудлуудыг шийдвэрлэнэ.

- (i) Гишүүд бүлгээрээ худгийн хамтын менежмент хэрэгжүүлэхээр тохиролцох
- (ii) Худаг ашиглах, засвар үйлчилгээ хийх хамтын хариуцлага хүлээх, үүргээ хуваан хэрэгжүүлэх (ахлагч, кассчин, засвар үйлчилгээ хариуцсан хүн гурав шийдэх)
- (iii) Худаг ашиглах, засвар үйлчилгээнд шаардагдах зардал, эхний удаа гишүүдээс гаргах мөнгөний хэмжээ, түүнийг хуримтлуулах арга, менежментийн аргын талаар тохиролцон шийдвэрлэх
- (iv) Бүлгээс гаргах худгийн засвар, үйлчилгээний зардал болон барилгын ажлын зардлаас бүлгийн хариуцах хэсгийн төлбөр төлөлтийн байдлыг хянахын тулд банкинд данс нээж, хуримтлалыг эхлүүлэх талаар бүлгийн гишүүд бүгд саналаа нийлүүлэх. (Барилгын ажлын зардлаас хариуцах хэсгийн хувьд улсад төлөх хэсэг ба сумын худгийн санд төлөх хэсгүүдэд хуваагдана)
- (v) Бүлгийн гишүүн бус өрх бүлгийн худгаас амны ба малын ус авах бол баримтлах журам, төлбөрийн хэмжээг тохирох (сумаас нэгдсэн журам, төлбөрийн хэмжээг сумандаа мөрдүүлэхээр гаргаж болно)

- (vi) Дээр дурьдсан асуудлаар гишүүд санал бүрэн нэгдэж тохиролцсон байх
- (vii) Худаг орчмын бэлчээрийг ашиглах төлөвлөгөө гаргах. Үүний тулд худгаа ашиглаж чадахгүй юм уу ашиглах боломжгүй үед (өөрөөр хэлбэл, ган зуд болох, төлбөр төлөх боломжгүй болох, төлбөр хугацаандаа төлөгдөхгүй саатах гэх мэт тохиолдлуудад) авах арга хэмжээг төлөвлөгөөнд тусгасан байх .
- Б. Бүртгүүлэх төлбөрөө хийсний дараа худаг сэргээн засварлах, шинээр гаргах саналаа хүргүүлэх
- В. Худаг ашиглах, засвар үйлчилгээний данс нээлгэх, мөнгө хуримтлуулж эхлэх. Кассчин төлбөр хийсэн байдлыг шалгаж, бүртгэл хөтөлнө. Хэн нэг нь өөрийн дураар данснаас мөнгө гаргахаас сэргийлэх зорилгоор хоёр ба түүнээс олон хүний гарын үсгээр гүйлгээ хийж байх (тухайлбал, ахлагч, кассчин)
- Г. Малчдын бүлгээс сумын ЗДТГ-т төлөх мөнгөний хувьд сумын ЗДТГ уг мөнгөнөөс сумын худгийн санд төлөгдөх ёстой хэсгийг сумын худгийн санд төвлөрүүлэн хуримтлуулна.
- Д. Малчид худаг гаргах, үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийхэд оролцох. Түүний зэрэгцээ худгийн ажиллагаа, бүтэцтэй танилцаж, шахуурга, мотор зэрэг тоног төхөөрөмжийн ажиллагаа, ашиглалтын аргын талаар мэдлэг ойлголт авна.
- Е. Худаг ашиглах гэрээг сумын захиргаатай байгуулж малчид гарын үсэг зурна. Гишүүдийн анхны хурлаар тохиролцож шийдвэрлэсэн асуудлууд гэрээнд тусгагдсан байх ёстой. Малчид хоёр дахь хурлаа хийж гэрээний агуулгыг бүх гишүүд батлана.
- Ё. Худаг ашиглалт, засвар үйлчилгээний талаар сургалт зохион байгуулж малчдыг хамруулна.
- Ж. Худгаа ашиглаж эхлэх. Бүлгүүд ашиглалтын ба засвар үйлчилгээний талаар бүртгэл судалгаа хөтөлж худгаа ашиглах, засвар үйлчилгээ хийх ажлыг үргэлжлүүлэн явуулна.

ii) Малчдыг зохион байгуулалтад оруулах ажиллагаа (Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах, малчдын орлогын байдлыг тогтворжуулах бүрэлдэхүүн хэсэг.)

МАН-н бүтээгдэхүүнийг сайжруулах, малчин өрхийн орлогыг тогтворжуулах бүрэлдэхүүн хэсэгт дурдсанчлан худаг байгуулалтаас бусад чиглэлээр бизнесийг дэмжин идэвхжүүлэх талаар бүлгийн үйл ажиллагааг ач холбогдлоор нь зэрэглэнэ. Хамгийн гол нь гаднын ямар нэг шахалтгүйгээр малчид, иргэд өөрсдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх эрүүл саруул ухаан, өмчлөгчийн сэтгэлгээгээр сайн дурын үндсэн дээр ажиллах явдал бүлгүүдийн хувьд юу юунаас чухал юм. Бүлэг болгон хариуцлагаа ухамсарлан, ил тод байж үйл ажиллагаагаа идэвхжүүлж чадваас зохион байгуулалтын ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чухал хувь нэмэр болох учиртай. Иймээс гэрээ, хэлэлцээрийн арга хэрэглүүр чухалд тавигдах ёстой.

Төслийг хэрэгжүүлэхэд захиргаанаас авч явуулрх тусгай арга хэмжээг дараахь хүснэгтэд харуулав.



Хүснэгт 5.5.2 Захиргаанаас малчид, иргэдийг зохион байгуулалтад оруулах талаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны дараалал

1. Бизнесийг дэмжин туслах талаархи төслийн мэдээллээр хангах, малчид, иргэдийн хоршилтын санаачлагыг баталгаажуулах
2. Малчид, иргэдийн бүлгийн хамтран үйл ажиллагаа явуулах санаачлагыг баталгаажуулах
3. Малчид, иргэдийн бүлгийн бизнесийн саналыг уламжлан хүргүүлэх
4. Төслийг захиргаанаас хянаж шалгаруулах (сумын захиргаа эсвэл сумын хурал)
5. Малчид, иргэдийн бүлэг ба сумын захиргааны хооронд гэрээ байгуулах (хэрэв санхүүжилт, тоног төхөөрөмж, материалын дэмжлэг авахаар төлөвлөсөн бол эргүүлэн төлөх хуваарь, тоног төхөөрөмж, материалын жагсаалт хавсаргагдсан байх ёстой.)

- 1) Малчид, иргэд зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулах чадвартай болно.

Дээр дурьдсан үйл ажиллагаа 2) ажлын байранд буюу газар дээр сургах хэлбэрээр хэрэгжих ба зохион байгуулалтын арга хэмжээ, ноу-хау-ийн менежментийн талаар мэдлэг олж авна.

- 2) Хөдөө орон нутгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, технологийг удирдах ажилтнууд олж авна.

Орон нутгийн удирдлага зохион байгуулсан бүх сургалтад хамрагдаж төслийн бүх хэсгүүдийн талаар ойлголт мэдлэгтэй болж технологи арга ажиллагааг эзэмшинэ. Өөрөөр хэлбэл, тэд ажлын байран дахь сургалтаар бүх технологи арга ажиллагааг эзэмшинэ.

- 3) Хөдөө орон нутгийг мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, технологийг малчид, иргэд эзэмшинэ.

Төслөөс зохион байгуулсан бүх сургалтад малчид, иргэд хамрагдаж төслийн бүх хэсгүүдийн талаар ойлголт мэдлэгтэй болж технологи арга ажиллагааг эзэмшинэ.

Түүнчлэн сургалтын явцад төлөвлөгөө зохиож, малчид, иргэд өөрсдийн ирээдүйн талаар төсөөлөл гарган юунд хүрэх шаардлагатай зүйлүүдийг төлөвлөх чадавхитай болно. Ийнхүү өөрсдийн эзэмшсэн туршлага, чадавхиа ашиглан санал бэлтгэж сумын захиргаанд хүргүүлнэ. (Сургалтын Үе шатны Менежмент буюу РСМ-ийн семинарыг туршилын судалгааны нэг загвар болгон ашиглана. Хавсралт "Төслийн Үе шатны менежментийн семинар"-ийг үзнэ үү.)

- (5) Хөрөнгө оруулалт

Хөдөө орон нутгийн Мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн сургалт, гарын авлага хийх зардал, малчид, иргэдийг хамруулсан төлөвлөгөөг боловсруулах сургалтын зардал.

(6) Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйл, ажил үүргийн хуваарь

Энэ бүрэлдэхүүн хэсэг нь бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэйгээ нягт уялдаа холбоотойгоороо чухал ач холбогдолтой юм. Мал аж ахуйг хөгжүүлэхэд шаардлагатай технологийн сургалт, семинаруудыг тогтмол явуулах замаар төслийн хэрэгжилтийг хангах боломжтой.

Аль ч бүрэлдүүн хэсгийн хувьд шаардлагатай технологийн арга хэмжээг доор харуулсанчлан тодорхой хэмжээгээр тогтоож болох юм. Гэвч мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах технологи нь хонины ноос боловсруулах, сүү боловсруулах гэх мэтчилэн олон талтай тул тухайн бүс нутгийн эрэлт хэрэгцээ, ирээдүйн шаардлагад нийцүүлэх байдлаар хандах нь чухал юм.

Хүснэгт 5.5.3 Төсөл тус бүрт шаардагдах чадварыг хөгжүүлэх чиглэл

Технологийн арга хэмжээ	Хамрагдагсад	Хэлбэр	Хөрөнгийн эх үүсвэр	Холбогдох төсөл	Холбогдох бүрэлдэхүүн хэсэг
Бэлчээрийн хэмжилт	Малчид	Товхимол тараах*а	ХХААЯ	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт
Гар худаг гаргах	Малчид	Товхимол тараах*б			
Худгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалтын технологи	Худгийн ашиглалтыг хариуцах малчдын бүлэг Сумын худгийн засварчин	Сургалт*с	ХХААЯ Аймаг (ЗДТГ)		
Мал үржүүлгийн технологи(зохиомол хээлтүүлэг зэрэг)	Малын эмч Малчид	Сургалт	ХХААЯ	Шилмэл малыг үржүүлэх	Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах
Мал аж ахуйн үндсэн технологи	Малчид	Сургалт, технологийн зааварчилга	ХХААЯ	Мал маллагааны арга барилыг сайжруулах	
Мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах технологи (хонины ноос боловсруулах, сүү боловсруулах)	Малчид Оршин суугчид	• Сургалт (Төрийн бус байгууллага) • Сургалтын аялал(Төрийн бус байгууллага амжилттай хэрэгжсэн төсөл)*d	Сумын хөгжлийн сан	Мал аж ахуй эрхлэлтийг сайжруулах	Малчдын эдийн засгийн чадавхийг тогтворжуулах
Зах зээлийн эдийн засгийн мэдлэг	Малчид Оршин суугчид	Сургалт*е	ХХААЯ	Мал аж ахуй эрхлэлтийг сайжруулах, Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, нийлүүлэлтийг сайжруулах	
Менежментийн чадвар (Байгууллагын менежмент)	Малчид Оршин суугчид	Сургалт*е	ХХААЯ	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төсөлд ч бас шаардлагатай)	

\*а: «Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт» Туршилтын төслийн хүрээнд зааварчилга гаргасан.(Хавсралт К)

\*б: «Гар худгийн камлани» Туршилтын төслийн хүрээнд зааварчилга гаргасан.(Хавсралт L)

\*с: «Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт» Туршилтын төслийн хүрээнд тоног төхөөрөмжийн засварчны сургалт зохион байгуулсан.

\*d: «Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах» Туршилтын төслийн хүрээнд хэрэгжүүлсэн.

\*е: «Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт», «Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах» болон «Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах» төслийн хүрээнд (оролцооны хэлбэрийн) сургалт явуулах замаар хэрэгжүүлсэн.

Тэрчлэн туршилтын төслийн хүрээнд технологийн сургалтын зардлыг төслөөс гаргасан бөгөөд цаашид малчдаас бүтнээр нь буюу хэсэгчлэн гаргуулах чиглэлийг барих нь зүйтэй юм. Ингэхдээ боловсруулах жижиг үйлдвэрлэлийн төсөлд олгох зээлийн дотор сургалтын зардлыг оруулж болно. Зээлийн эх үүсвэрийн хувьд Сумын хөгжлийн санг идэвхитэй ашиглах шаардлагатай юм.

Мөн хүний нөөцийн хөгжлийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд чухлаар тавигдах асуудлын нэг бол бүс нутгийн боловсон хүчнийг идэвхитэй ашиглан, сургалтыг удирдах багш нарыг орон нутгаас сонгон авах явдал болно. Ингэвэл нутгийн малчид сургалтын дараа ойлгомжгүй зүйлээ тодруулан асуух, асуулт тавих боломж бүрдэх юм. Улаанбаатараас багш ирүүлсэн тохиолдолд харилцаа холбоо, тээврийн хэрэгслийн хувьд хязгаарлагдмал малчид ойлгомжгүй эргэлзээтэй зүйл байсан ч хаяад явахаас өөр аргагүй болохоос гадна сургалтын зардал өндөр гарна.

Хүснэгт 5.5.4 Хүний нөөцийн хөгжлийн (чадварыг хөгжүүлэх) төсөлд оролцогчдын ажил үүргийн хуваарь

Хэрэгжүүлэх байгууллага	Үйл ажиллагаа
Засгийн газар (ХХААЯ)	<ul style="list-style-type: none"> <li>• Бэлчээр хэмжилтийн зааварчилгыг тараах, тогтмол хугацаанд засварлах</li> <li>• Бүх төрлийн сургалтын төлөвлөгөөг гаргах, хэрэгжүүлэх, засварлах</li> </ul>
Аймаг (ЗДТГ)	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалт удирдах багш болох чадвартай хүмүүсийн судалгааг гаргах</li> <li>• Технологийн сургалтын төлөвлөгөөг гаргах, хэрэгжүүлэх</li> <li>• Сургалт (менежментийн болон технологийн) явуулах.</li> <li>• Алслагдсан нутгийн малчдыг сургалтанд хамруулах.</li> </ul>
Сумын ЗДТГ	<ul style="list-style-type: none"> <li>• Мал аж ахуй эрхлэлтийг сайжруулах төслийн хүрээнд жижиг хэмжээний бүтээгдэхүүн боловсруулах бүлгийг тодруулах</li> <li>• Багш нарыг тодруулж, аймагт мэдэгдэх</li> </ul>
Малчид	<ul style="list-style-type: none"> <li>• Бэлчээр, худаг ашиглалт, мал аж ахуйн бүтээгдэхүүний жижиг хэмжээний боловсруулалтын төслийн саналыг гаргаж, сумын ЗДТГ-т өгөх</li> <li>• Тухайн бүс нутагт технологийг нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулах</li> </ul>

## 5.6 Бичил төслүүдийг хэрэгжүүлэх чиглэл

“Бэлчээр ашиглалт худаг байгуулалтаас” бусад бүрэлдэхүүн хэсгүүд нь олон талтай, баялаг агуулгатай болно. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Гэвч өргөн уудам нутгийг хамрах тул энэ ажилд ихээхэн цаг хугацаа шаардагдахаас гадна улсын төсвөөс хуваарилагдах хөрөнгийн ихэнх нь бодит байдал дээр “худаг байгуулалтанд” зарцуулагдаж байгаа тул нарийвчилсан төлөвлөгөө боловсрууллаа гэхэд уг төслийг хэрэгжүүлж эхлэх хүртэл ихээхэн сунжрах магадлал өндөр байдаг. Өнөөдөр орон нутгийн засаг захиргааны юуны өмнө санаачилгыг гартаа авч, хэрэгжих боломжтой төслүүдийг нэн даруй хэрэгжүүлэн, орон нутгийн хөгжлийг түргэтгэх чухал зорилт тулгарч байна.

Энэхүү судалгааны хүрээнд “худаг байгуулалт, бэлчээр ашиглалт”-аас бусад хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд болох “Малжуулах сан”, “Сүүн бүтээгдэхүүн”, “Ноос боловсруулах” зэрэг бичил төслүүдийг туршилтаар хэрэгжүүлж ирлээ.

“МАН-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах” бүрэлдэхүүн хэсэг



“Малжуулах сан” төсөл нь дараах зурагт харуулсанчлан “Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах” бүрэлдэхүүн хэсгийн 3 төслийн үзэл санааг агуулахаас гадна, “Хүний нөөцийн хөгжлийн” бүрэлдэхүүн хэсэгтэй ч холбогдож байна. Энэ төсөл нь ядуурлыг бууруулахад

чиглэсэн арга хэмжээний хувьд ихээхэн онцлогтой боловч орон нутгийн нөхцөл байдалд зохицуулан тухайн салбарт эрэл хайгуул хийх замаар олон талт байдлаар хэрэгжүүлэх боломжтой юм.

Худаг байгуулалтын төслийн хүрээнд малчдын бүлэг байгуулбал энэ бүлэг нь дараагийн шатанд “Сүүн бүтээгдэхүүний” үйл ажиллагаа явуулж, бүлгийн гишүүдийн бэлэн мөнгөний орлогыг нэмэгдүүлэх замыг эрэлхийлээд явах нь тийм ч хэцүү зүйл биш юм.

Энэхүү судалгааны хүрээнд малчид, иргэд, сумын засаг захиргааны зүгээс “Малжуулах сан”, “Сүүн бүтээгдэхүүн”, “Хонины ноос боловсруулах”, “Арьс шир боловсруулах”<sup>1</sup> төслүүдийг хамгийн ихээр сонирхож байгаа нь тогтоогдсон болно. Эдгээрээс гадна “Ногоо тарих”, “Тэжээлийн ургамал тариалах”, “Малын үүлдрийг сайжруулах”, “Бичил зээл” зэрэг олон төслүүдэд ач холбогдол өгч байна. Эдгээрийн дотор “Усны чанарыг сайжруулах”, “Цөлжилтийг багасгах” зэрэг технологийн хувьд хүндрэлтэй олон төслүүд дурьдагдаж байгаа боловч ихэнх нь сумын засаг захиргааны санаачлагаар бага хэмжээний хөрөнгөөр хэрэгжих боломжтой бичил төслүүд байлаа.

Нарийн технологи шаардах бүс нутгийн хэмжээний томоохон төслийг хэрэгжүүлэхэд харьцангуй их цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулагдах тул орон нутгийн засаг захиргаа өөрсдийн хүчээр хэрэгжүүлэх боломжтой бичил төслүүдийг боловсруулан, хэрэгжүүлэх чиглэлд хүчин чармайлт гаргах шаардлагатай. Иймэрхүү бичил төслүүдийг хэрэгжүүлэх явцад харьцангуй том төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх ур чадвараа дээшлүүлэх үндсэн дээр дараагийн шатанд шилжин явах нь зүйтэй юм.

<sup>1</sup>Туршилтын судалгааны хүрээнд арьс шир боловсруулах төслийн хувьд хамгийн энгийн аргаар түүхий арьс ширний боловсруулалт хийснээр борлуулах үнийг нэмэгдүүлэх арга болгон зуны улиралд арьс хадгалах технологийг сайжруулах, өвлийн цагт малчид арьс ширээ хамтран цуглуулах ба борлуулах ажлын талаар авч үзсэн боловч арьс ширний чанар хангалтгүй, өртөг бага, нам температурын хөргөлттэй агуулах шаардлагатай гэх мэтийн шалтгаанаас арьс боловсруулах төслийг хэрэгжүүлээгүй болно.

## 5.7 Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Ерөнхий төлөвлөгөөний дагуу гаргасан төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар доор өгүүлье.

### (1) Төслийн агуулга ба тэргүүлэх дараалал

“3.5 Хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн тэргүүлэх дараалал” гэсэн хэсэгт өгүүлснээр “Бэлчээрийн менежмент, худаг байгуулалт” нь хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах төслийн нэн тэргүүний, суурь төсөл юм. “МАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг сайжруулах”, “Малчин өрхийн орлогыг тогтворжуулах” болон “Хүний нөөцийг хөгжүүлэх” зэрэг нь “Бэлчээрийн менежмент, худаг байгуулалт”-ын төслийг иж бүрэн болгох нэмэлт төслүүд бөгөөд хөдөөгийн мал аж ахуйн хувьд чухал ач холбогдолтой.

Төрийн захиргааны төв байгууллага (ХХААЯ)-ын хувьд дээрх нэмэлт төслүүдийг өөр чиглэлийн (тус яаманд харьяалагдахгүй) төсөл гэж үзэх асуудал буй хэдий ч хамгийн доод шатны хэрэгжүүлэгч байгууллага (сум)-ын хувьд ингэж ялгавартай хандалгүй, эдгээр төслүүдийг аль болох эн тэгш зэрэгцүүлэн урагшлуулж явбал бүх төслүүдээс цогц нэгдмэл үр дүн гарах юм.

### (2) Төлөвлөгөөний нарийн тодорхой байдал

#### 1) Худаг байгуулалтын төсөл

Худаг байгуулалтын төлөвлөгөөн дэх худгуудтай холбоотой суурь мэдээллүүдийн хувьд доор дурдсанчлан ялгаатай байна.

Хүснэгт 5.7.1 Худагтай холбоотой мэдээллийн тойм.

	Бүх өвөлжөө, хаваржаанууд болон худгуудын байршил, бусад хүчин зүйлүүдийг магадлан шалгах	Усны нөөцийн цахилгаан соронзон хайгуул	Худгийн мэдээлэл
Туршилтын судалгаанд хамрагдсан 3 сумдад	Хэрэгжүүлсэн	Эрдэнэ суманд 28 цэгт, Улаанбадрах суманд 40 цэгт, Хөвсгөл суманд 20 цэгт.	UNDP-гийн мэдээ, баримтыг Дорноговь аймгийн ХААГазар ба судалгааны баг хамтран засаж, шинэчилсэн. Худаг сэргээн засварлах боломжийг тодорхойлох судалгаа.
Дорноговь аймгийн бусад сумдад	Хэрэгжүүлээгүй	Сумдын гаргасан хүсэлтэд үндэслэн сум бүрт 10 орчим цэгт	UNDP-гийн мэдээ, баримтыг Дорноговь аймгийн ХААГазар ба судалгааны баг хамтран засаж, шинэчилсэн.
Дундговь, Өмнөговь аймгуудад	Хэрэгжүүлээгүй	Хэрэгжүүлээгүй	UNDP-гийн мэдээ, баримт

Иймд тус төлөвлөгөөг туршилтын төсөлд хамрагдсан сумдаас өөр сумдад хэрэгжүүлэх болбол худгийн мэдээлэл (худгуудын тухай мэдээ, баримт, тэдгээрийг сэргээн засварлах боломж)-ийг шалгаж үзэх зайлшгүй шаардлагатай.

## 2) Худгаас бусад төслүүд

Эдгээр төслүүд нь агуулгын хувьд орон нутгийн онцлог ба хэрэгжүүлэгчдийн санаа зоригоос шалтгаалан ялгаатай байж болно. Гэхдээ төслийн бүтэц зохион байгуулалтын хувьд "4-р бүлэг. Туршилтын төслийн судалгаа" гэсэн хэсэгт дүйцүүлэн хэрэгжүүлэх боломжтой.

## (3) Худаг байгуулалтын төслийн бэлтгэл ажил

Худаг байгуулалтын төслийг хэрэгжүүлэхийн тулд "Зураг 5.2.7 Худаг байгуулалтын процесс"-т үзүүлсний дагуу малчдыг зохион байгуулалтад оруулах ажлыг эхлүүлэх шаардлагатай. Ингэхдээ аймгаас бүх сумдад худаг байгуулалтын ажлын чиглэлийг өгч, сумд түүний дагуу сумынхаа худаг байгуулалтын ажлыг тодорхойлон малчдад өргөн зарлан мэдээлэх ба худагтай болох хүсэл бүхий малчид бүлэг байгуулан худгийн барилгын ажлын зардлаас өөрсдийн төлөх хэсгийг хуримтлуулж эхлэх юм.

## (4) Төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай болох тухайд

### 1) Барилгын ажилд шаардагдах хугацаа

Худгуудын төрлийн хувьд инженерийн ба гар худаг гэсэн ялгаатай боловч, дунджаар 1 суманд 100 орчим цэгт худаг сайжруулахаар төлөвлөгдсөн байгаа. Эдгээрээс бараг тал хувь нь гар худаг байгаа бөгөөд энэ нь ердийн үед ч гэсэн явагдаж байдаг сэргээн засварлах ажил дээр нэмээд 1 сумын хэмжээнд жилд 5 цэгт гар худаг шинээр гаргахаар төлөвлөсөн байгаа нь боломжийн тоо гэж үзэж байна. Гардан хэрэгжүүлэгчид нь малчид байх болно. Гэхдээ бүх сумд гар худаг байгуулалтын ажлыг бодитойгоор хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох шаардлагатай. Төлөвлөлтийн хувьд "4.6.6 Гар худгийн кампанит төсөл" гэсэн хэсгийг ашиглаж болно.

Харин инженерийн худгийн хувьд барилгын ажлын явцад нөлөөлөхүйц байна. Сайжруулах инженерийн худгийн тоог гаргаж ирэхдээ, малчдыг 100% зохион байгуулалтад оруулах нь бэрхшээлтэй тул зохион байгуулалтын хувь хэмжээг 80%-иар бодож, үүнээс худаг төлөвлөлтийн тоог гаргаж ирсэн. Говийн бүсэд 4-өөс 10-р саруудад буюу жилд 7 сарын хугацаанд өрөмдлөгийн төхөөрөмжийг ажиллуулж болно. Өрөмдлөгийн төхөөрөмжийн дундаж хүчин чадлаас, аймаг тус бүр дэх барилгын ажилд шаардлагатай нийт хугацааг тооцоолон гаргавал доорх байдалтай байна.

### Хүснэгт 5.7.2 Барилгын ажилд шаардагдах хугацааны тойм тооцоо

Ажлын төрөл	1 цэг дээрх ажилд зарцуулагдах хугацаа	Жилд хэдэн цэгт өрөмдлөг явуулах боломжтой	Төлөвлөсөн тоо			Шаардагдах хугацаа (жилээр)		
			Дунд говь	Дорно говь	Өмнө говь	Дунд говь	Дорно говь	Өмнө говь
Гүний худаг	2 долоо хоног	14 газар	74	115	91	5.3	8.2	6.5
Богино яндант худаг	2 долоо хоног	14 газар	210	106	208	15.0	7.5	14.9
Гүний худаг сэргээн засварлах	1 долоо хоног	28 газар	94	53	82	3.4	1.9	3.0
Богино яндант худаг сэргээн засварлах	1 долоо хоног	28 газар	42	21	57	1.8	0.7	2.0
Уурхайн худаг сэргээн засварлах	3-4 хоног	56 газар	161	175	74	2.9	3.1	1.4
нийт						28.4	21.5	27.7

※Жилд ажиллах хугацаа гэдэг нь 11 сараас 3 сар хүртэлх 5 сарыг хасаж тооцсон хугацаа болно.

1 Гүйцэтгэгч байгууллага өрөмдлөгийн төхөөрөмж 2-3 –ыг ашиглан, нийт 5 жилд ажлыг багтаан дуусгахаар тооцвол аймаг бүрт 2-3 барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага ажиллахаар байна.

#### 2) Барилгын ажлыг үе шаттайгаар гүйцэтгэх

1 суманд дунджаар 30-40 инженерийн худаг байна. 1 суманд жилд 40 цэгт худгийн ажил гүйцэтгэх нь маш бэрхшээлтэй тул 1 суманд 2-3 жилийн хугацаанд энэхүү ажлыг хэрэгжүүлэх юм. Аймаг бүр 14-15 сумтай, 3-4 сумыг 1 бүлэг болгон ажлын талбарт хувааж, 1 аймаг дахь барилгын ажлыг 5 жил орчим хугацаанд дуусгахаар байна.

Мөн, барилгын ажлыг 3 аймагт зэрэг явуулахад ажлын хэмжээ хэт ихсэж, төслийн менежментийн тал дээр бэрхшээлтэй болох талтай, мөн барилгын ажлын зардлыг худаг ашиглагчдаар буцаан төлүүлэх гэсэн шинэ систем нэвтрүүлэн туршиж ажиллангаа ажлыг бүрэн гүйцэд хэрэгжүүлэх шаардлагатай тул үүнийг доор үзүүлсэнчилэн үе шаттайгаар хэрэгжүүлэх нь зүйтэй. Нарийвчилсан төлөвлөгөөнд хамрагдсан бүс нутаг болох Дорноговь аймагт худаг байгуулалтын ажлыг эн тэргүүний ээлжинд хийж гүйцэтгэх нь бодит сонголт болно гэж үзэж болно.

### Хүснэгт 5.7.3 Барилгын ажлын төлөвлөгөө

	Жил											
	0	1	2	3	4	5	6	7	8	9	10	
Дорноговь	→											
Өмнөговь					→							
Дундговь							→					

#### (5) График төлөвлөгөө (Төслийн мөчлөг Project Cycle)

Дээрх ажлыг хэрэгжүүлэх график төлөвлөгөөг 5.7.4 дүгээр зурагт үзүүлэв. 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр тооцлоо.

### Хүснэгт 5.7.4 Ажлын гарафик

	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	
Эхний жил				•ХХААЯ-тай ярилцах, • албан контор нээх, • монгол ажилтан элсүүлэх, • машин унааны асуудлыг шийдэх	• Дорноговь аймагт албан контор нээх, • Аймагтай ярилцах, • Суман дээрх тайлбарлах уулзалт, • Газар дээрх судалгаа зэрэг		• Газар дээрх судалгаа, • Сумдтай ярилцах	• Малчдыг цуглуулж уулзах, • Төслийн санал цуглуулах	• Төхник технологийн засвар оруулах, • Төхникийн шаардлага боловсруулах	Барилгын ажлын зардлыг тооцоолж, улс ба донор хөрөнгө оруулагчдын зөвшөөрлийг авах	• Тоног төхөөрөмжийн тендер ба гэрээ	• Гэрээний зөвшөөрөл	
2 дахь жил	• Худаг шинээр байгуулах ба сэргээн засварлах ажлын тендер	Гүйцэтгэлийн гэрээ, • Санамж бичиг/сум төслийн баг, малчдын хооронд/ Малчдын бүлгээс хариуцах зардлаа төлөх	• Тоног төхөөрөмжөө авч эхлэх	• Худаг шинээр барих, сэргээн засварлах ажлыг эхлүүлэх				• Малчдыг цуглуулж уулзах, • Төслийн санал цуглуулах	• Төхник технологийн засвар оруулах, • Төхникийн шаардлага боловсруулах	Барилгын ажлын зардлыг тооцоолж, улс ба донор хөрөнгө оруулагчдын зөвшөөрлийг авах	• Тоног төхөөрөмжийн тендер ба гэрээ	• Гэрээний зөвшөөрөл	
Адил агуулгатай ажлыг жил бүр давтах.													
								Худаг ашиглалтын мониторинг					

### (6) Худгийн төслийн явц ба ажил үүргийн хуваарь

Худгийн төслийг эхлүүлснээс хойш ашиглаж эхлэх хүртэлх ажлын явц ба тухайн хугацаанд малчид, орон нутгийн захиргаа буюу улс, хөрөнгө оруулагч доноруудын гүйцэтгэх ажил үүргийн хуваарь нь доорх байдалтай байна.

### Хүснэгт 5.7.5 Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төслийн явц ба ажил үүргийн хуваарь

Д/д	Малчид	Сум /аймаг/	Улс буюу донор	Тайлбар
1		Төслийн агуулга ба хэрэгжүүлэх арга замын талаарх ярилцлага /туршилтын төсөлд хамрагдаагүй сумд/		
2		Малчдыг уриалах /төслийн санал цуглуулах/	/тусламж үзүүлэх/	
3	Төсөл хэрэгжүүлэхээр хүсэлт гаргах: Зохион байгуулалтад орох, хүсч буй худгаа нэр дэвшүүлэх	Малчдыг зохион байгуулалтад оруулах	/тусламж үзүүлэх/	Нэрсийн жагсаалт, хариуцагч, малын тоо толгой, худаг ба бэлчээр ашиглалтын зураг
4		Зөв зүйтэй (оновчтой) байдлыг судлах		Худгийн байршил ба төрөл, усны хайгуул, засвар үйлчилгээ хийх боломж, бусад бүлгүүдтэй өрсөлдөх өрсөлдөөн зэрэг.
5	-Хариуцах зардлаа төлөх -Засвар үйлчилгээний сан байгуулах	/тусламж үзүүлэх/	/туслах ба магадлан шалгах/	ХААН банкинд данс нээх
6	/Малчид оролцоно/	Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалт /PO Workshop/		Ажил үүргийн хуваарийг тодруулах
7	/Малчид оролцоно/		Худгийн барилгын ажил	Малчид ажиллах хүч гаргана.
8	/Тухайн худгийг ашиглаж болох эсэхийг эцсийн байдлаар шалгах/		Усны чанарыг шалгах	Усны чанарын судалгаа
9	Худаг ашиглалтын тухай гэрээ байгуулах			
10	Худгаа ашиглаж эхлэх			



Туршилтад хамрагдсан 3 сумдын хувьд эдүгээг хүртэл сум ба судалгааны багийн хооронд байнга санал солилцож ирснээр уг төслийн агуулга, судалгааны зорилгыг сайтар ойлгуулсан ба бусад сумдын тухайд RRA (хөдөөг оролцооны аргаар үнэлэх) судалгаа зэргээр тойролт хийх үеийн хязгаарлагдмал харьцаа төдийгээр хязгаарлагдаж байсан тул төслийн агуулга ба хэрэгжүүлэх арга замын тухай бүрэн танилцуулж, сумдын ойлголтыг гүнзгийрүүлэх шаардлагатай.

Уг төсөл нь худаг байгуулалтыг bottom up /дороос санал дэвшүүлэх/ хэлбэрээр урагшлуулах ажил тул худгийн барилгын ажлыг эхлүүлэх хүртэлх үйл явц чухал үүрэгтэй. Малчид, худаг ашиглах бүлгийг өөрсдөө байгуулж, ажил үүргийнхээ хуваарийг тогтоон, засвар арчлалтын санг байгуулж, барилгын ажлын зардлын тодорхой хэсгийг хариуцах нь "худагт барилгын ажлыг эхлүүлэх" урьдчилсан нөхцөл юм. Өөрсдийн худагтай болох гэсэн ухамсрыг нь өндөржүүлэхийн тулд барилгын ажлын явцад ч гэсэн бололцооных нь хэрээр ажилллах хүч гаргуулах нь чухал.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд усны чанар сайнгүй тул худгийн барилгын ажлын дундуур буюу ажил дууссан хойно усны чанарын судалгаа хийж, малчдаас ашиглана гэсэн саналыг нь авсны дараа худгийг ашиглуулж эхлэх нь зүйтэй.

Нутаг дэвсгэр өргөн уудам тул бүх сумдад судалгаа ба барилгын ажлыг нэгэн зэрэг эхлүүлнэ гэдэг бэрхшээлтэй. Иймд нийт нутгийг 3 блокод хувааж, 1 блокийн ажлыг дуусгаад дараагийнх руу нь шилжин орох байдлаар бус 2-3 удаагийн эргэлтээр ажлыг дуусгах хэлбэрээр ажлын төлөвлөгөөг гаргаж, төсөл аймгийг бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй байхаар байлгах явдал чухал.

#### (7) Худгаас бусад төслүүдийн явц ба ажил үүргийн хуваарь

Худгаас бусад төслүүдийн хувьд ч гэсэн малчид, орон нутгийн засаг захиргаа болон улс, донорууд тус бүр тухайн төсөлд гүйцэтгэх өөрсдийн ажил үүргийг хуваарийн дагуу хэрэгжүүлэх нь чухал.

#### Хүснэгт 5.7.6 Худгаас бусад төслүүдийн ажлын явц ба ажил үүргийн хуваарь

Д/д	Малчид	Сум (аймаг)	Улс, донорууд	Тайлбар
1	Төслийн санал гаргах	(тусламж үзүүлэх)		Хялбар ярилцлага
2			Төслийн санал сонгон шалгаруулах	Сонгон шалгаруулалтын хэмжүүр (нөхцөл)-ийг тогтоох, сумтай ярилцах
3	Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах (PO Workshop)			Төсөлд оролцогчдын ухамсрыг төлөвшүүлэх, зардал хариуцах тухай тодруулах
4			Төсөл төлөвлөх	ТЭЗҮ судалгаа, төсөв
5	Төслийг танилцуулах ба эцсийн байдлаар магадлан шалгах			Хариуцлагын асуудлыг тодруулах
6	Төсөл хэрэгжүүлэх	(тусламж үзүүлэх)		
7		Мониторинг, үнэлгээ		

Малчдын техник, технологийн түвшин, эдийн засгийн тогтвортой байдлыг харгалзан төслийг сонгон шалгаруулж явах нь чухал юм.

## **БҮЛЭГ 6 Дүгнэлт, зөвлөмж**



## Бүлэг 6 Дүгнэлт, зөвлөмж

Дор дурдсан зөвлөмж нь 2003 оны 3 дугаар сараас 6 дугаар сар хүртэл судалгаа явуулж боловсруулсан гурван аймгийн "Ерөнхий төлөвлөгөө", 2003 оны 7-р сараас 2004 оны 2-р сарын хооронд явуулсан судалгааны явцад боловсруулсан Дорноговь аймгийн "Нарийвчилсан төлөвлөгөө" болон гурван суманд 2004 оны 3 дугаар сараас 2006 оны 1 дүгээр сар хүртэл хийж гүйцэтгэсэн туршилтын судалгааны үр дүнд үндэслэгдсэн болно.

Эдгээр зөвлөмжүүдээс (1), (3), (4)-ийг бэлчээрийн ангиллаар "цөлөрхөг хээр" ихэнх хувийг эзэлж буй бүс нутгийн худаг байгуулалтын ажилд ашиглаж болох юм. Мөн (2), (5), (6), (7), (8), (9)-ийн хувьд худаг байгуулалтын үндсэн ажлуудын талаар дурдсан тул улсын хэмжээнд ашиглах боломжтой юм.

### (1) Худаг сэргээн засварлах ажлыг түрүүлэн хэрэгжүүлсэн үндэслэл

Говийн бүсийн олон хүний амьдрал мал аж ахуйгаас хамаардаг, мал аж ахуйг зохистой арга замаар эрхлэх нь хүрээлэн буй орчныг хамгаалахад тустай бөгөөд орон нутагт мал аж ахуй хөгжүүлэх асуудал Монгол улсын үндэсний хөгжлийн салшгүй хэсэг мөн билээ.

Усны нөөц нь гол төлөв газрын доорхи усаар тодорхойлогддог говийн тухайд худаг бол хүний амьжиргаанд төдийгүй мал сүрэгт чухал шаардлагатай. Говьд худаг эвдрэх, тоногдох явдал газар авснаас бэлчээрийн нөөц, чадавхийг үр өгөөжтэй ашиглаж чадахгүйд хүрч байгаа нь бэлчээрийн менежмент, худаг сэргээн засах асуудлыг мал аж ахуйг цаашид тогтвортой хөгжүүлэхэд чухал гэдэг талаас нь харах шаардлагатай болжээ.

Гүн, ундрага сайтай, сайтар тохижуулсан гар болон инженерийн хийцтэй худаг гаргах, байгуулах замаар усны хангамжийг тогтворжуулах боловч орон нутгийн засаг захиргаа, малчдын чадавхи хараахан хүрэхгүй учраас төрөөс үзүүлэх хөрөнгө мөнгөний туслалцаа дэмжлэг зайлшгүй чухал болж байгаа юм. Түүнчлэн малчид өөрсдөө худгаа засаж тохижуулна гэвэл хэтдээ бэлчээр ашиглалт эмх замбараа муутай болох эрсдэлтэй учраас засаг захиргааны байгууллага энэ ажилд оролцох зүйтэй юм.

Энэхүү судалгаанд санал болгож буй бэлчээрийн менежмент, худаг засан сайжруулах үйл ажиллагаа нь ашиглалтгүй болон бага ашигладаг бэлчээр, худгийг үр дүнтэй ашиглах шаардлага хэрэгцээтэй холбоотой юм. Иймд эдгээр төлөвлөгөөг холбогдох бүх байгууллагуудаар аль болох эрчимтэй, нэн түрүүнд хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газраас тодорхой чиглэл өгөх нь зүйтэй гэж зөвлөж байна.

Эдгээр ажлуудыг буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, эсвэл Монгол улсын хөрөнгө оруулалт аль алианаар нь хэрэгжүүлэх боломжтой. Ингэхдээ Монгол Улсын хувьд ажлын үр шимийг хүртэгчдээр барилгын ажлын зардлын тодорхой хувийг хариуцуулж байхаар шийд гарсан хэдий ч энэ хэлбэрийн дагуу хэрэгжүүлсэн ажлын бодит туршлага бага байгаа, худгийн засвар арчлалтын ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд худаг ашиглагчдын бүлгийг зохион байгуулж ажиллуулах нь чухал, ингэж зохион байгуулалтад оруулахад цаг хугацаа их шаардагдана гэдгийг сайтар бодолцож үзэх нь зүйтэй. Иймд худаг байгуулалтын ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхдээ дээрх чиглэлийн сургалт сурталчилгааны ажлыг хангалттай хэмжээнд зохион байгуулах шаардлагатай.

Мөн, говийн бүс нутаг дахь худаг байгуулалтын ажилд зөвлөмж (3), (4)-т дурдсанчлан говийн бүс нутаг хэмээх онцлогийнх нь үүднээс худаг байгуулалтын ажлын төсвийг бүх сумдад бага багаар хуваарилан тарамдуулах бус, тодорхой бүс нутагт төвлөрүүлэх нь илүү үр дүнтэй (5.6 Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг үзнэ үү).

(2) Худгийн ашиглалт, засвар үйлчилгээ чухал болох тухай

Улсын хөрөнгө оруулалтаар сэргээн засварласан худагт дахиад тийм хөрөнгө оруулалт хэзээ ч хийгдэхгүй нь мэдээж. Инженерийн хийцтэй худагт тавьсан насос, мотор нь ашиглалтын тодорхой хугацаатай учраас гамтай ашиглахгүй бол аажимдаа муудсаар цагаасаа өмнө эвдэрч ажиллахгүй болдог. Түүнээс гадна эвдэрсэн худгийн тоног төхөөрөмжийг засварлах боломж суманд байхгүй, буцаагаад үйлдвэрлэсэн газар луу нь юм уу Улаанбаатарт хүргүүлж засуулах болно. Гэтэл говийн бүс алслагдсан учраас тээвэрлэж хүрэх, засуулахад ихээхэн цаг орохын дээр зардал ч нэлээд гарна. Хэрэв малчид худгаа ашиглаж засвар үйлчилгээ хийж чадахгүйд хүрвэл хөрөнгө хүч зарж байж гаргасан, сэргээн засварласан худгийг ашиглах асуудал төвөгтэй болж ирнэ.

Ийнхүү ялангуяа алслагдсан говийн бүс нутгийн хувьд худгийн засвар арчлалтын асуудал онц чухал байдаг. Холбогдох хүмүүсийн хувьд худаг барих ажилд анхаарал хандуулж буй хэдий ч барилгын ажил, засвар арчлалтын ажлыг цогц байдлаар авч үзэх *lū ç¿éòúé*.

Худгийн засвар арчлалтын ажлыг хэрэгжүүлэхдээ худгийнхаа засвар арчлалтыг хариуцагчид болох малчдыг зохион байгуулалтад оруулах шаардлагатай ба ингэхийн тулд засаг захиргааны ажилтнуудыг сургаж, малчдын зохион байгуулалтад орохыг нь дэмжиж ажиллуулах шаардлагатай (5.5 Хүний нөөцийг хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсгийг үзнэ үү).

Худгийн тоног төхөөрөмжийн засвар арчлалтыг малчдын бүлэг анхнаасаа дагнан явуулах нь техникийн тал дээр хүндрэлтэй. Иймд худгийн тоног төхөөрөмжийн засвар арчлалтыг хийж чадахуйц мэргэжилтнийг бүх сумдын ЗДТГ дээр бэлтгэх, сэлбэг хэрэгслийг сумын ЗДТГ нөөцөлж, худалдаалах зэргээр бүлгээс явуулах худгийн засвар арчлалтын үйл ажиллагааг сумын захиргаанаас дэмжих тогтолцоо бий болгох ажлыг худаг байгуулалтын ажилтай зэрэгцүүлэн хэрэгжүүлж явах шаардлагатай (5.2.8 дугаар зургийг үзнэ үү).

- (3) Бэлчээрийн менежмент, худаг сэргээн сайжруулах арга хэмжээг говийн бүсийн онцлогт тохируулан явуулах тухай

Ялангуяа цаг уурын хэлбэлзэл ихтэй говийн бүс нутагт бэлчээрийн байдал жил бүр өөрчлөгддөг тул малчид сайжруулсан худгийнхаа ойр орчны бэлчээрийг жил бүр тогтвортой ашиглаж чадалгүй, малаа авч худгаасаа холдож нүүх магадлал ихтэй. Ийм учраас говийн бүсэд малаа адгуулан нүүдэллэх хүрээ маш өргөн уудам байдаг онцлогтой, жилийн туршид ашиглах худгийн тоо ч олон байна. Иймээс эдгээр олон тооны худгуудын байрлах бүс нутгийг үр ашигтайгаар ашиглаж чадахуйц тогтолцоо хэрэгтэй байгаа юм.

Малчдын 1 бүлэг өөрийн эзэмшиж буй худгаасаа гадна ялангуяа шаардлагатай үед бусад малчдын бүлгүүдийн эзэмшилд буй худгийг ч гэсэн саадгүй ашиглаж чадахаар байхын тулд эдгээр худаг эзэмшигч бүлгүүд хоорондоо худаг ашиглах хэлэлцээ байгуулах маягаар өргөн уудам бүс нутгийн худаг ашиглалтыг нийтэд нь хянах тогтолцоо хэрэгтэй. Өөрөөр хэлбэл "Бүлэг зөвхөн өөрийн эзэмшлийн худгаа ашиглах явдлыг өргөн уудам бүс нутаг дахь бусад худгийг ч гэсэн ашиглах явдалтай холбож өгөх" байдлаар сэтгэлгээг нь өөрчилж явах шаардлагатай. Эдгээр худгуудын ашиглалтыг зохицуулах газар нь зөвхөн сумын ЗДТГ байх юм.

Сумын ЗДТГ сумын хэмжээн дэх малчдын худаг ашиглалтын байдал ямар байгаа талаар байнга бүрэн ойлголттой байхын тулд малчдын ашиглаж буй худгуудыг тэмдэглэсэн газрын зурагтай болох шаардлагатай.

- (4) Говийн бүс нутгийн бэлчээрийг өмчлүүлэх асуудлын талаар

Зөвлөмж (3)-т өгүүлсэнчлэн говийн бүс нутгийн бэлчээр байдал нь цаг агаарын бага зэргийн өөрчлөлтөөс шалтгаалан маш хувирамтгай, малчид сумынхаа хил хязгаарыг давж, өөр сумын бэлчээр ашиглах явдал их гардаг. Ийм бүс нутгийн хувьд бэлчээрийг өмчлүүлэх журам гаргаад ч малчид бэлчээр ашиглалтын журмыг дагаж мөрдөнө гэдэг үнэндээ боломжгүй юм.

(5) Худаг сэргээн сайжруулах төлөвлөгөөг сумаас хариуцан хэрэгжүүлэх шаардлага

Малчдын бүлгүүд өөрсдийн бэлчээр нутгийн заагийн дотор юм уу ойролцоо газар шинэ худагтай болохыг эрмэлзэх болсон нь худаг сэргээн засварлах ажил ашиглалтгүй юм уу ашиглалт багатай бэлчээрийг сумынхны хүсэж байгаачлан ашиглалтын эргэлтэд оруулахад дорвитой хувь нэмэр болох нь тэр бүр бага.

2005 оны 7 дугаар сард ХХААЯ, БОЯ, СЭЗЯ-наас хамтран гаргасан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-д худаг сэргээн засварлах, сайжруулах ажлыг сумаас хариуцан гүйцэтгэж болно гэж заасан. Ган, зудын эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд худаг зайлшгүй чухал гэдэг агуулгаар авч үзвэл малчдын бүлэг худгаа зохих журмын дагуу ашиглахыг сонирхохгүй байгаа тохиолдолд ийм худгийн ашиглалтад сумаас хяналт тавьж хэрэгжүүлэхээр сумын төлөвлөгөөнд тусгах нь илүү зохимжтой юм. Ийм байдлаас ашиглах худгийн тоог сумаас менежмент хэрэгжүүлэх чадвахийг харгалзан 2-3 байхаар тогтоож, шаардагдах зардлыг сумаас гаргаж болох юм. Хөрөнгө оруулагчтай тохиролцон "худгийн сан" байгуулах, эсвэл засгийн газраас зохих хувийг гаргаж энэ ажлыг өөр хувилбаруудаар хэрэгжүүлэх боломжтой.

Худгийг ашиглагчид нь шаардагдах бүх зардал хөрөнгийг хариуцах зарчимтай байх ба худаг ашиглалтын төлбөр, менежментийн арга замаа тодорхойлоод аймагт мэдэгдэнэ. Сумын ЗДТГ-аас хяналт тавих худаг ашиглалтын төлбөр хоорондоо харьцангуй их ялгаатай байвал энэ ажлыг удирдан зохион байгуулж буй сумын ЗДТГ-т үл итгэх байдал үүсч, сумын худгийн сангийн бүрдэлтэд муугаар нөлөөлж болзошгүй. Иймд аймаг худгуудын ашиглалтын төлбөр сумдад харьцангуй их ялгаатай тогтоогдсон байх тохиолдолд үүний шалтгааныг тодруулж, шаардлагатай бол өөрчлөлт оруулахыг даалгаж болох юм.

(6) Худаг сэргээн сайжруулахад малчдаас оруулсан хувь хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх

"Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-д худаг гаргах, сэргээн засварлах ажил эхлэхээс өмнө ашиглагчид нь шаардагдах хөрөнгө зардлын тодорхой хувийг гаргахаар заасан. Энэ дагуу худаг гаргах, сэргээн засварлах ажлын гүйцэтгэгч нь зардлаа төсөвлөхдөө ашиглагчдаас оруулах хувь хэмжээтэй дүйцэх хөрөнгийг урьдчлан төсөвд тусгах боломжтой байх ба ашиглагч нь энэхүү төлбөрөө нэг дор төлөх ёстой.



Гэтэл өөрийн оруулах хувь хэмжээг төлөх чадвартай малчдын бүлэг тун цөөхөн, энэ ч учраас сумын зүгээс худаг гаргах, сэргээн засварлахад оруулах хөрөнгөө гаргах, үгүй бол энэ зорилгоор мөнгөн хөрөнгө шуурхай хуримтлуулах чадвартай, цаашдаа худгаа найдвартай ашиглаж чадах малчдын бүлгийг олж шалгаруулан сонгох ажлыг эртнээс хийж эхлэх хэрэгтэй. Зарим тохиолдолд сум шаардлагатай зардлаа хуримтлуулсны дараа худаг барих хүсэлтийг зохих байгууллагад гаргах болно.

Улсаас, худаг байгуулалтын ажлын төсөв мөнгө гаргасан ч гэсэн малчдын бүлгийн хариуцах зардал бэлэн болохгүй бол барилгын ажлыг урагшлуулж чадахгүй болох тул худаг байгуулалтын ажлыг худаг ашиглагч бүлгүүдийг дотор нь томсгон бүлэглэж, тухайн бүлгүүдээр худаг гаргах, сэргээн засварлах мөнгө хөрөнгө бэлдүүлэх ажлыг үндэсний хэмжээнд кампанит ажил болгон явуулах, худаг шинээр гаргахад хүчин чармайлт тавих талаар олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг хамтатган хийвэл зохистой.

(7) Ашиглалт, засвар үйлчилгээний тогтолцоо бий болгох шаардлага

Малчид одоогоор инженерийн хийцтэй худгийн талаар мэдлэг, ойлголт муутай хэвээр байна. Худаг ашиглах явцад малчдын чадавхиас хэтэрсэн асуудал гарвал бэрхшээл тохиолдох магадлалтай олон зүйл байгаа юм. Ийм зүйл гарлаа гэхэд газар дээр нь шийддэг байвал сайн бөгөөд үүний тулд худаг засах, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөлтийн хүрээнд худгийн ашиглалт, засвар үйлчилгээний бүтэц бий болгох шаардлагатай.

Худгийн ашиглалт, засвар үйлчилгээний тогтолцооны хүрээнд сумын захиргаа нэлээд гол чухал үүргийг хариуцах болно. Засварын ажлыг хүндрэл багатай шийдэж байхын тулд сумын захиргаа зөв хүнээ сонгож сургаж бэлтгэх, сэлбэг материалын зохих нөөц бүрдүүлэх шаардлагатай. Сумандаа хийх боломжгүй засвар үйлчилгээг аймгийнхаа худаг усны компаниар хийлгэж байх нь чухал.

Энд яригдаж буй тогтолцоо бий болгох арга хэмжээг аймаг болон үндэсний хэмжээнд хамтатган хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

(8) "Сумын худгийн сан байгуулах" шаардлага ба худгийн тогтвортой ашиглалт, засвар үйлчилгээ

Дээр дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд сумаас гүйцэтгэх үүргийн тухай ярих үед төсөв хөрөнгө дутагдалтай гэсэн том асуудал босч ирдэг.

Энэ асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ болгон худаг гаргах, засварлах явцад малчдаас арай ахиу мөнгө гаргуулах, малчдаас гаргах хувь хэмжээнээс илүү

гарсныг нь сумын захиргаанаас санаачлан "сумын худгийн сан" байгуулж төвлөрүүлэх талаар тодорхой бодлого явуулахыг зөвлөх нь зүйтэй гэж үзнэ.

Худгийн санд төвлөрсөн хөрөнгийг сумын хэмжээнд худаг сайжруулахад, түүний дотор худаг гаргахад хөрөнгөө оруулсан малчдыг дэмжих чиглэлээр зарцуулах ба ийнхүү санхүүгийн тусламж үзүүлдэг болчихвол худаг сайжруулах ажил үр дүнтэй хэрэгжихэд зохих түлхэц өгөх учиртай юм.

(9) Орон нутгийн захиргааны удирдлагын чадавхи чухал болох тухай

Богино хугацааны судалгааны явцад мал аж ахуйд хэрэгжүүлсэн жижиг төслийн хүрээнд нэг юм уу хоёр худаг засах юм уу сэргээх хэмжээний хөрөнгө олдохтой үгүйтэй учраас санхүүжүүлэгч төлөвлөгдсөн зардлыг нь суманд олгох нь зүйтэй бөгөөд ингэснээр бодит зардал харьцангуй багасах юм.

Орон нутгийн захиргаанд зохих чадавхи бий болгож чадаагүй тохиолдолд ямар ч төсөл хэрэгжүүлээд үр дүн гарахгүй нь мэдээж. Төслийн төлөвлөлтийн шатанд сумын захиргааны чадавхийн асуудлыг нухацтай авч үзвээс төсөл хэрэгжүүлэх явцад улам бүр идэвхжиж ирэх болно. Хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нь сум цааш нь залган хөгжүүлэх чадавхитай болговол тэр нь төслийн томоохон амжилтын нэг байх нь гарцаагүй. Жижиг бизнесийн санаа сэдэл, агуулга өөр өөр байдаг учраас сумаас зохицуулан хэрэгжүүлэх боломжтой янз бүрийн төсөл нэлээд байх боломжтой. Иймээс орон нутгийн чадавхид таарах төслүүдийг хэрэгжүүлэх замаар орон нутаг (сум)-ынхныг идэвхжүүлэн дэмжихэд засгийн газар анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Нөгөө талаар, зарим баг малчдаасаа мал авч сан бүрдүүлэн малчдын амьжиргааг энэхүү сангаар дамжуулан тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байна. Худаг сайжруулах уламжлалт ажлыг идэвхжүүлэхийн тухайд малчдад харьцангуй ойр дөт байдаг (судалгааны явцад тогтоогдсон) багийн чадавхийг бэхжүүлэх нь илүү чухал, шаардлагатай юм. Гэхдээ сум, багийн одоогийн чадавхи боломжийн хүрээнд чухам юу хийж, хэрэгжүүлэх боломжтойг юуны өмнө тусгайлан судлах хэрэгтэй болно.

(10) ГМС-ийн мэдээллийн шинэтгэл ба өргөтгөл

Уг судалгаагаар говийн 3 аймгийн бэлчээр, уст цэгийн талаарх ГМС (газарзүйн мэдээллийн систем)-ийн мэдээлэл боловсруулах ажил хийгдсэн.

Эдгээр мэдээллийн дотор худгийн байгууламжийн байдал ба хяналт тавигч, худаг ашиглалтын байдал зэрэг жил бүр шинэчлэх шаардлагатай

мэдээллүүд бий. Ийм мэдээллийг сумд жил бүр цуглуулж, аймгийн ХАА-н газар түүнийг нэгтгэж байх нь зүйтэй.

Бусад аймгуудын хувьд ч уг судалгааны явцад боловсруулсантай адил материалыг бэлтгэн ГМС-ийг ашигласан төлөвлөгөө боловсруулах ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай.

(11) Туршилтын төслийн дараах үйл ажиллагаа

Туршилтын бүх төслүүд хэрэгжилтийн шатандаа явж байна. Төсөл бүрийн явцыг сумын захиргаанаас хянаж үнэлэх (мониторинг хийх), улмаар шаардлагатай тохиолдолд холбогдох өөрчлөлт, зохицуулалтыг хийж байх явдал шаардагдаж байна.

Төсөл хэрэгжүүлж байгаа сумд ажлынхаа талаар тогтоосон хугацаанд аймагтаа тайлагнах, аймаг ч гэсэн тодорхой хугацаанд хэрэгжилтийн явцтай танилцаж байх нь чухал.



# ХАВСРАЛТ



## ХАВСРАЛТ – А

Судалгааны ажлыг хэрэгжүүлэх нарийвчилсан журам болон  
Хэлэлцээний санамж бичгүүд

---





SCOPE OF WORK

FOR

THE STUDY

ON

IMPROVEMENT PLAN OF LIVESTOCK FARMING SYSTEM IN RURAL AREA IN

MONGOLIA

AGREED UPON BETWEEN

MINISTRY OF FOOD AND AGRICULTURE

AND

THE JAPAN INTERNATIONAL COOPERATION AGENCY

ULANBAATAR, OCTOBER 3, 2002

I INTRODUCTION

In response to a request from the Government of Mongolia (hereinafter referred to as the "GOM"), the Government of Japan (hereinafter referred to as the "GOJ") has decided to conduct the Study on Improvement Plan of Livestock Farming System in Rural Area in Mongolia (hereinafter referred to as "the Study") in accordance with the relevant laws and regulations in force in Japan.

Accordingly, the Japan International Cooperation Agency (hereinafter referred to as "JICA"), the official agency responsible for the implementation of the technical cooperation programs of the GOJ, will undertake the Study in close cooperation with the authorities concerned of the GOM.

The present document sets forth the Scope of Work for the Study.

II OBJECTIVE OF THE STUDY

The objectives of the Study are:

1. To formulate a plan of actions to utilize pastureland and to manage wells for mitigating overgrazing situation, and thus contribute to the alleviation of damages caused by dzud and to the stabilization of livestock farming.
2. To carry out technology transfer to Mongolia counterparts through on-the-job training in the course of the Study.

III STUDY AREA

The Study will cover the priority area(s) in aimags of Gobi and Steppe zone.

IV SCOPE OF THE STUDY

In order to achieve the above objectives, the Study shall consist of three (3) phases and shall cover the following items:

1. Phase I

<Main issue>

- Collection and analysis of basic data

- Formulation of the plan for pasture utilization system and of the plan for construction, rehabilitation, and maintenance of wells in line with the plan for pasture utilization system.

<Study item>

1) Diagnostic Analysis

1)-1 to select the three (3) aimags as survey area,

1)-2 to review of livestock farming development policy, plan, and project,

1)-3 to carry out field survey and collecting data such as natural condition, social condition, pastoral production, distribution condition, economic condition

Mr. P. Dandondorj  
State Secretary,  
Ministry of Food and Agriculture

Witnessed by

Mr. Kh. Amarsaikhan  
Director General,  
Economic Cooperation, Management and  
Coordination Department  
Ministry of Finance and Economy

Mr. Kiichi Marita  
Leader,  
Preparatory Study Team,  
Japan International Cooperation Agency

Handwritten initials and signature at the top right of the page.

others for the effective pastureland utilization and for operation and maintenance of wells.  
 c. to strengthen the administrative systems of the organizations concerned.

- <Study item>
- 3-1 to implement the experimental study for the components clarified in Phase II,
- 3-2 to monitor and evaluate the process of activities for the experimental study,
- 3-3 to formulate the final report.

V STUDY SCHEDULE

The Study will be carried out in accordance with the attached tentative schedule (ANNEX). The schedule is to be modified when both sides agree upon any necessity that will arise during the course of the Study.

VI REPORTS

JICA shall prepare and submit the following reports in English to the GOM:

- 1 Inception Report  
Twenty (20) copies in English at the commencement of the Phase I.
- 2 Interim Report 1  
Twenty (20) copies in English at the commencement of the Phase II.
- 3 Progress Report 1  
Twenty (20) copies in English at the end of the Phase II.
- 4 Interim Report 2  
Twenty (20) copies in English at the commencement of the Phase III.
- 5 Progress Report 2  
Twenty (20) copies in English during the course of the Third phase of work.
- 6 Draft Final Report  
Twenty (20) copies in English after the end of third phase of work in Mongolia. The GOM shall provide JICA with its comments on the Draft Final Report within one (1) month of receipt of the Draft Final Report.
- 7 Final Report  
Fifty (50) copies in English within two (2) months of receipt of GOM comments on the Draft Final Report.

VII UNDERTAKINGS OF THE GOVERNMENT OF MONGOLIA

- 1 To facilitate smooth conduct of the study, the GOM shall take necessary measures:

*[Handwritten signature]*  
P.D.

of herders, activities of herders, and others.

- 1)-4 to recognize present surrounding condition of livestock farming,
- 2) Formulation of the plan for pastureland utilization system
- 2)-1 to analyze the present condition of pasturing capacity and overgrazing.
- 2)-2 to collect the information of pasture land management.
- 2)-3 to analyze the appropriate pasture utilization system and control method for appropriate number of livestock,

3) Formulation of the plan for construction, rehabilitation, and maintenance of wells in line with the plan for pasture utilization system,

- 3)-1 to analyze the present condition of wells and its utilization by herders,
- 3)-2 to collect the information of hydrogeological condition,
- 3)-3 to analyze the operation and maintenance system of wells,
- 3)-4 to propose the areas for well construction and rehabilitation,

4) Main issue

- Formulation of the detailed plan for sustainable livestock farming management system (include pasture utilization system)
- Formulation of the detailed plan for construction, rehabilitation, and maintenance of wells in line with the plan for pasture utilization system
- <Study item>
- 2-1 to select the detailed survey area (equivalently one (1) aimag),
- 2-2 to plan and implement exploration (geophysical and hydrogeological surveys) for wells, and thus identify the types and locations toward their construction,
- 2-3 to estimate construction and rehabilitation cost,
- 2-4 to prioritize the wells for their construction and rehabilitation,
- 2-5 to select areas for the experimental study based on criteria set during the study,
- 2-6 to clarify the components of experimental study.

3- Phase III

- <Main issue>
- implementation of the experimental study with following purposes:
- a. to verify the validity of the plan for pastureland utilization system and for operation and maintenance of wells.
- b. to enhance skills of Mongolian counterpart personnel and

*[Handwritten signature]*  
P.D.

- 4-1 available data and information related to the Study,
- 4-2 counterpart personnel,
- 4-3 suitable office space with necessary equipment and furniture in Ulaanbaatar and survey sites, and
- 4-4 credentials or identification cards.

VIII UNDERTAKINGS OF JICA

